

ДУГААР 1.4

GovAsia

Азийн Сангийн эрхлэн гаргадаг улирал тутмын хэвлэл



The Asia Foundation

ХАҢОЙГООС ХАЙДЕРАБАД

АЗИЙН ХОТУУДАД АМЬДАРЧ БУЙ ЭМЗЭГ БҮЛГИЙН
ЭМЭГТЭЙЧҮҮДЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛСЭН
НӨЛӨӨ

2021 ОНЫ 12 ДУГААР САР

GovAsia сэтгүүлийн 1.4 дэх дугаарт тавтай морилно уу. Улирал тутамд хэвлэгддэг GovAsia сэтгүүл нь Азийн Сан болон үүний түншлэгч байгууллагуудад тус Сангийн зүгээс бүс нутгийн хөгжлийн сорилтуудыг даван туулах чиглэлээр өдөр тутам явуулж буй үйл ажиллагаандаа үндэслэн Ази тивийн хэмжээнд иргэд, Засгийн газруудын нүүр тулж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн асуудлаар судалгаа хийх үндсэн платформ болдог билээ. GovAsia нь бүс нутагт өнөө тулгарч буй засаглалын хамгийн чухал, ноцтой асуудлаар тунгаан бодох, хэлэлцүүлэг өрнүүлэх, шийдлийн талаар зөвшилцөлд хүрэх арга замыг эрэлхийлэн бий болгох зорилготой.

Энэ дугаарт Ази тивийн найман хотод КОВИД-19 цар тахлын үзүүлсэн олон төрөл нөлөөллийг судалсан. Энэхүү дугаар нь 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 4 дүгээр сарын хооронд Кор Глобал (Kore Global) байгууллагатай хамтран хийсэн, жендэр, үндэс угсаа, бага цалин, баталгаат бус ажлын байр зэрэг олон талт эмзэг байдлын улмаас хотжилтын үр шимийг хязгаарлагдмал хүртэж буй хүмүүсийн өнөөгийн нөхцөл байдал, хэтийн төлөв дээр хийсэн судалгаанд үндэслэгдсэн. Бид ирээдүйд үүсэх нөхцөл байдлыг тодорхойлох, илүү хурдан өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж болох Ковид-19 цар тахлын өмнөх болон цар тахлын үеийг судлан үзэх замаар өнөөгийн тэгш бус байдлын үндсэн хүчин зүйлсийг судлан үзсэн. Төрийн албан тушаалтан, хөгжлийн салбарын ажилтнууд нь зөвхөн эдийн засгийн хязгаарлагч үзүүлэлтээс илүүг харж, олон талт хандлагыг ашиглан цар тахлаас хүний болон санхүүгийн капитал, чадамжид үзүүлж буй, үзүүлэх нөлөөллийг тодорхойлон, улмаар үйл ажиллагаандаа ашиглана хэмээн бидний зүгээс найдаж байна.

ЗОХИОГЧИД: Сумаяа Салуца (Sumaya Saluja), Салли Невилл (Sally Neville), Ребекка Калдер (Rebecca Calder), Никола Никсон (Nicola Nixon), Мандакини Сурие (Mandakini Surie).

СУДЛААЧИД: Садиа Афозе Султана (Sadia Afroze Sultana), Норовсамбуугийн Ариунаа, Гантуяагийн Цолмон, Болдбаатарын Халиун, Дүгэрсүрэнгийн Оргил, Сапованн Рассапонг (Sopavanh Rassapong), Саконе Доуанпачан (Sakhone Douangphachanh), Соумлэтай Паликхан (Somleuthay Phalikhanh), Тамара Фейлор (Tamara Failor), Тран Чун Чай (Tran Chung Chau), Фарва Рашид Минхас (Farva Rashid Minhas), Махвиш Жавед Хан (Mahwish Javed Khan).

ХЯНАГЧ: Ким Маккуай (Kim McQuay), Тамара Фейлор (Tamara Failor), Пола Юниаки (Paula Uniacke), Гупа Тампил (Gopa Thampi), Кази Бин Сераж (Kazi Faisal Bin Seraj), Тодд Вассел (Todd Wassel), Питер Иатес (Peter Yates), Дэвид Ней (David Ney).

РЕДАКТОР: Сюзан Нолан (Suzan Nolan), Лаура Пиерсон (Laura Pierson).

ХАВТАСНЫ ЗУРАГ: Ханой хотын барилгын ажилчин. Фото зургийг JunPhoto

Энэхүү хэвлэлтийг Австралийн Гадаад Харилцаа, Худалдааны Яамны (DFAT) зүгээс санхүүжүүлсэн. Тайланд илэрхийлсэн үзэл бодол, үр дүн, тайлбар, дүгнэлт нь зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлэх ба Азийн Сан эсвэл Австралийн Засгийн газрын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.



Энэхүү бүтээл нь Creative Commons Attribution-Non Commercial 4.0 олон улсын лицензийн хүрээнд хамаарна.

 **The Asia Foundation**

456 California Street, 9th Floor
San Francisco, CA U.S.A 94104
www.asiafoundation.org

GovAsia

ТОЙМ

КОВИД-19 цар тахал Азийн хотуудаар түрэмгийлэн тархаж эхэлснээр хүн амын өндөр нягтаршил бүхий хот суурин газрын ядууралд өртсөн олон тооны хүн ам, албан бус ажиллах хүчний цар хүрээ зэргээс шалтгаалан үзүүлэх сөрөг нөлөөлөл нь улам ихээр нэмэгджээ. Тухайн хотуудад тархсан цар тахал нь анги давхарга, жендэр, угсаатан ястан болон бусад эмзэг үзүүлэлтийн хувьд өмнө хэдийн үүсэн бий болоод байсан тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлжээ. Энэхүү судалгаа нь КОВИД-19 цар тахлаас үзүүлсэн сөрөг нөлөөллийг хот суурин газрын эмзэг бүлгийн ажилчид, ялангуяа эмэгтэйчүүдийн нүдээр судлан, баримтжуулж, цар тахал болон өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал хоорондын ээдрээт, олон талт харилцан уялдааг задлан шинжилсэн. Судалгаа нь бүс нутгийн 8 хотын 80 хүнтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийж, цар тахлын үеийн нөхцөл байдал, тулгарсан сорилтууд, даван туулах, дасан зохицох боломж, ирээдүйн тухай бодлыг нь ярилцан судалсан.

Ярилцлагад хамрагдсан хүмүүс Засгийн газрын авч хэрэгжүүлсэн цар тахлыг зогсоох хариу арга хэмжээний (эсвэл хөл хорио) эхэн үеэс л санхүүгийн шок мэдэрч эхэлсэн бөгөөд олонхынх нь хувьд энэ нөлөөлөл өнөөг хүртэл үргэлжилж байна. Ярилцлагад оролцсон зарим хүмүүсийн зүгээс санхүүгийн капиталын их хэмжээний алдагдалд орсноор ядуурлын баталгаажих доод түвшнээс доош орж, түрээсийн төлбөр, хүүхдийнхээ хэрэгцээт зүйлсийг хангах эсвэл эм хэрэгсэл худалдан авахын хооронд хүнд хэцүү шийдвэр гаргахад түлхжээ. Цах тахлаас өмнө ч хангалттай орлого олж чаддаггүй байсан хүмүүсийн хувьд огт орлогогүй болох нь маш хүндээр тусжээ.

Хэдийгээр Засгийн газрууд нь тодорхой арга хэмжээ авч, цар тахлын нөлөөг бууруулахаар хичээсэн ч эмзэг бүлгийн иргэдэд энэхүү дэмжлэг туслалцааны хүртээмж хаалттай байжээ. Төрийн дэмжлэггүйгээр олон хүн өөрийн нийгмийн капитал болох гэр бүл, найз нөхдийн туслалцаанд найдаж, зээл авах, шинэ ажил хийх, хүүхдээ харуулах, бичил бизнесээ авч үлдэх боломжийг эрэн хайжээ. Тэдгээр хүмүүсийн нийгмийн капитал нь хомсдолтой байсан тул хот суурин газрын ажил эрхлэгч олон хүмүүс ямар сонголтгүй, юу хийхээ ч мэдэхгүй байдалд оржээ. Ярилцлагад оролцсон хүмүүсийн зүгээс өөрсдөдөө үүссэн түгшүүр, стресс, удаан хугацаанд найдваргүй байдалд орсон мэт санагдаж байснаа дурдсан.

Бидний хийсэн ярилцлагад оролцогчдын ихэнх нь эмэгтэйчүүд байв. Олон эмэгтэй цар тахлаас үүдэн ажил хайх, бизнесийн үйл ажиллагаа нь доголдох, ажлын ачаалал нэмэгдэх зэрэг асуудалтай тулгарсны зэрэгцээ ар гэрийн ажил, хүүхэд асрах зэрэг олон ажлыг зохицуулах шаардлагатай болж, цөхөрсөн болохоо ярьж байв. Хөл хорио, хязгаарлалтын үеэр ядууралд өртөх хугацаа уртассан, шилжилт хөдөлгөөн хязгаарлагдсан зэрэг асуудлууд хослон өөрийн сүлжээ, танил талын хүрээнд дэмжлэг тусламж хайх, өгөх боломжийг нь бүр бууруулсан байна. Нийгмийн хамгаалал, аюулгүй байдал, дэмжлэг туслалцаа байхгүй ба нийгмийн капитал хомс байдлаас улбаалан хүмүүс богино хугацаанд даван туулах стратеги болох бусдаас мөнгө зээлэх, эд хөрөнгөө зарах, эрүүл мэндийн даатгалд түргэн хамрагдах зэрэг арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлжээ. Гэвч энэ стратеги нь тогтвортой бус бөгөөд урт хугацаандаа нөхцөл байдлыг нь улам л муутгахуйц байв.

Хүүхэд хөгшид асрах, гэрийн ажил хийх зэрэг эмэгтэйчүүдэд ноогдох үүрэг хариуцлага нэмэгдсэн нь цаашдын санхүүгийн баталгаат бус байдал зэрэг урт хугацааны нөлөөлөл үүсгэж байв. Түүнчлэн, өрхийн гол орлогыг эрчүүд олдог эмэгтэйчүүд гэрийн ажил хийдэг гэх хоцрогдмол хөдөлмөрийн хуваарь зарим гэр бүлийн хувьд эргэн сэргэжээ. Зарим эмэгтэйчүүдийн өмнөө тавьсан ажил мэргэжлийн цаашдын төлөвлөгөөнд саатал учирч, өрх дэх тэдний нөлөө буурсан байна. Ажилгүй болох, боловсрол олох явц саатах зэрэг бусад сөрөг нөлөөлөлтэй хослон цаашид гарах урт хугацааны нөлөөлөл нь олон жилийн туршид тэмцэсний үр дүнд бий болж буй эмэгтэйчүүдийн бие даасан, хараат бус байдлыг улам бууруулж болно.

Энэхүү дүн шинжилгээ болон дүгнэлтээр өгч буй бодлогын зөвлөмжүүд нь цар тахлын өргөн хүрээний нөлөөллийн эсрэг хот суурин газруудын ажил эрхлэгч эмэгтэйчүүд, эмзэг бүлэгт зориулан илүү хүртээмжтэй, тэгш байдлыг хангасан, иж бүрэн хариу арга хэмжээ авах боломжийг хангана хэмээн найдаж байна.

1. ТАНИЛЦУУЛГА

АЗИЙН ХОТУУД ДАХЬ ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ТЭГШ БУС БАЙДАЛ

Түүхэн үүднээс харвал хот суурин газрууд нь хүмүүст ажил эрхлэх илүү сайн боломж бүрдүүлж, бараа, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёл болон нийгмийн олон янз байдлыг бүрдүүлж ирсэн түүхтэй. Гэвч Ази тивийн олон хотын амьдралаас хүртэх өгөөж нь анги, каст, үндэс угсаа, жендэр болон бусад үзүүлэлтээр тэгш бус хуваарилагдаж байх хандлагатай байдаг. Бүс нутгийн олон тооны ядуу, эмзэг бүлгийн хүн ам нь хотуудын бий болгож буй өгөөжөөс ангид байсаар байна.

Энэ нөхцөл байдал нь 2020 оны эхээр КОВИД-19 цар тахал дэлгэрэхийн өмнө ч бодитоор оршиж ирсэн юм. Цар тахал Азийн тивийн хотуудад асар хурдтай, түрэмгийлэн тархсан ба дэлхийн хэмжээнд гарсан нийт халдварын 90% нь хот суурин газруудад бүртгэгдсэн байна.¹ Хүн ам шигүү суурьшсан байдгийн улмаас хотууд нь КОВИД-19 халдвар тархах явцыг хурдасгаж, цар тахлаас үзүүлж буй сөрөг нөлөөллийн хүнд ачааг хотуудын эмзэг бүлгийнхэн үүрчээ. НҮБ-ын мэдээлснээр “КОВИД-19 нь хотуудын орон зай, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг илүү өргөжүүлэн, өөрийн энэхүү сөрөг тойргоор дамжуулан вирусийн халдварыг илүү хөнөөлт байдалд хүргэсэн” байна.² Зарим тохиолдолд цар тахлыг таслан зогсоох арга хэмжээ нь тэгш бус байдлыг хамруулаагүйн зэрэгцээ үүнийг улам нэмэгдүүлж, энэ нь ирэх жилүүдэд ч үргэлжлэхээр байна.

Цар тахлын тухай хийгдэж буй бүхий хэлэлцүүлэгт тэгш бус байдлын талаар тусгах нь дутмаг байжээ. Тэгш бус байдлын оронд Засгийн газрын хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, халдварын тархалтыг зогсоох арга хэмжээ, вакцины хангалт зэргийг л түлхүү ярьцгааж байв. Улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзвэл цар тахлын гол нөлөөлөл нь орон нутагт хамгийн хүндээр илэрч

буй юм. Судлаач Мередит Вайсс (Meredith Weiss) “Үндэсний төлөвлөгөө, удирдамж, статистик зэрэг нь ач холбогдолтой ч хувь хүмүүсийн хувьд төвөөс гаргасан журам, орон нутаг дахь хэрэгжилтийн уулзвар болох орон нутаг дээр л цар тахлыг мэдэрсэн” хэмээн үзжээ.³

Судалгааны энэхүү тайланд КОВИД-19 цар тахлаас үзүүлсэн сөрөг нөлөөллийг хот суурин газрын эмзэг бүлгийн ажилчид, ялангуяа эмэгтэйчүүдийн нүдээр судлан, баримтжуулж, цар тахал болон өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал хоорондын ээдрээтэй, олон талт харилцааг задлан шинжилсэн. Судалгаа нь бүс нутгийн 8 хотын 80 хүнтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийж, цар тахлын үеийн нөхцөл байдал, тулгарсан сорилтууд, даван туулах, дасан зохицох боломж, ирээдүйн талаарх бодлынх нь тухай ярилцсан юм. КОВИД-19 нь хөдөө орон нутагтай харьцуулбал хот суурин газруудад хүн амын нягтаршил, чанар муутай орон сууцны нөхцөл, албан бус ажил эрхлэгчдийн өндөр хувь хэмжээ зэргээс үүдэн вирусийн тархалтыг хянахад ихээхэн ээдрээтэй, төвөгтэй байсан тул бид энэхүү судалгааг хотуудад суурилан хийсэн.

Ази тивийн бага, дунд орлоготой олон бүс нутаг⁴, мөн Өмнөд бүсийн олон газарт төлөвлөлтгүй хотжилт нь ядуу, эмзэг нөхцөл байдалтай, үүнд ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжгүй хүн амын нягт суурьшлыг бий болгожээ. Ажил, амьдралын хүнд нөхцөл нь өвчлөл, осолд өртөх өндөр эрсдэл, эдийн засгийн хүндрэл, үйлчилгээний хязгаарлагдмал хүртээмж зэрэгтэй хослон нөлөөлж байна.⁵ Тиймээс хот суурин газрын ядуу иргэд КОВИД-19 халдвар авсан тохиолдолд эрүүл мэндийн болон бусад үйлчилгээг авах боломжгүй байжээ. Хөдөө орон нутагтай харьцуулбал хотуудад бизнесийн үйл ажиллагааг зогсоох, иргэдийн зорчих хөдөлгөөнийг хориглох зэрэг арга хэмжээ илүү хатуу хэрэгжсэн тул зарим хүмүүсийн хувьд цаашид гарч болох үр дагавраас нь эмээсний улмаас үйлчилгээ авахаас цааргалах тохиолдол гарч байжээ. Зорчих

хөдөлгөөн хориглосон явдал нь хөдөө орон нутгаас цагаачлан ирсэн, хот суурин газарт суурь үйлчилгээ авахад шаардлагатай оршин суух баримт бичиггүй олон сая дотоодын дүрвэгчдэд илүү хамааралтай байна. Бусад хүмүүсийн хувьд тухайн үйлчилгээний хүртээмжийг хангахад тус болох гар утас зэрэг шинэ технологи ашиглахад шаардлагатай мэдлэг чадвар дутмаг байжээ.

Бага орлого, баталгаат бус амьжиргаа, нийгмийн халамжийн сул хөгжсөн тогтолцоо зэрэг нь КОВИД-19 халдвар авсан хүмүүс, ажил хийх боломжгүй хүмүүс болон хөл хорио, зай барих зэрэг тархалт хязгаарлах арга хэмжээнд өртсөн хүмүүст цар тахлаас үүдсэн санхүүгийн сөрөг нөлөөлөл улам нэрмээс болжээ. Олон хүмүүсийн хувьд тэдний ажил эрхлэлтийн төрөл нь амьжиргаагаа залгуулах боломжийг нь тодорхойлж байдаг. Хот суурин газруудын ядуусын тоонд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бичил бизнес эрхлэгчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, таарсан ажлаа хийж амь зуудаг хүмүүс багтах ба эдний хувьд ажлын байргүй болох өндөр эрсдэл тулгарсан.⁶ Түүнчлэн, хот орчмын эсвэл хөдөө орон нутгаас ирж ажил хийдэг ажилчид, мөн үйлчилгээний салбар болон богино хугацаагаар идэвхэждэг эдийн засгийн салбарын ажилчид зайнаас ажиллах боломжгүй байсан тул орлого нь их хэмжээгээр буурсан байна. Энэ нөхцөлд орсон хүмүүс санхүүгийн хувьд эргэн сэргэхийн тулд урт зам туулах шаардлагатай тулгарах магадлалтай юм.

Нөгөө талаар Азийн хотуудын чинээлэг оршин суугчид цар тахлын үеэр ч амьжиргаагаа тогтвортой хадгалж, улам сайжруулжээ. Саятан, тэрбумтнууд илүү баяжиж, капитал хөрөнгийг илүү ихээр эзэмшиж,⁷ мэргэжлийн болон удирдах түвшний анги давхарга гэрээсээ ажиллах замаар өөрийн орлогоо хамгаалан үлдэх тусам Азийн хотууд дахь баялгийн, нийгмийн, орон зайн тэгш бус байдал улам л нэмэгдэх магадлалтай юм. Үүний зэрэгцээ жижиг бизнес эрхлэгчид, дунд түвшний ажилчид цар тахлаас үүдэн бизнесийн үйл ажиллагаа хаагдсанаас үүдсэн зардлаа санхүүжүүлэхээр чармайх бол ажил эрхэлдэг ядуу иргэд, ажилгүй ядуу иргэд, ядуурлын ирмэгт буй хүмүүс илүү гүн ядууралд өртөж байна. Азийн хотуудын эдийн засгийн ноён нуруу болдог, томоохон хэмжээний үл үзэгдэгч албан

бус ажилчдад өмнө тулгарч байсан асуудлуудыг цар тахал улам тодруулан, эдийн засаг, нийгмийн хязгаарлалт нь тэдгээр хүмүүсийг хүнс, орон сууц, нийгмийн халамжийн үйлчилгээнээс гадуур хүртээмжгүй үлдээсэн байна.

Цар тахлаас үүдсэн жендэрийн тэгш бус байдал ч улам гүнзгийрэх төлөвтэй байна. Хот суурин газрын ядуу бүсүүдэд амьдарч буй хүмүүсээс гүйцэтгэлээр цалинждаг үйлдвэрлэл зэрэг байнгын бус, баталгаагүй ажил эрхэлдэг эмэгтэйчүүд эсвэл үндэстний цөөнх зэрэг уламжлалт эмзэг бүлгийн хүмүүст цар тахал нь нэмэлт эмзэг байдлыг үүсгэжээ. Энэ нөхцөлд эмэгтэйчүүдэд эрх мэдэл байхгүй, албан болон албан бус шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж хязгаарлагдмал байна. Үүний улмаас боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн үйлчилгээний тэгш бус хүртээмж бий болж, тэдний амьжиргаа, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж, улмаар тэдний зүгээс эдийн засаг, нийгэмд оруулах хувь нэмрийг бууруулж буй нь эдийн засгийн өсөлтөд саад тотгор учруулж байна.⁸ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зүгээс 2021 онд Ази, Номхон далайн бүс нутагт эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хувь хэмжээ нь цар тахлын өмнөх үеэс давах бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ нь 2019 оны түвшнээс доогуур байх төлөвтэй гэж үзжээ.⁹ Цар тахлаас үүдэн сургууль хаагдаж, ажил бизнес зогссоноор хүүхэд, төрөл садан, нутгийн иргэдийг асрах урт удаан хугацаанд тогтсон эцгийн эрхт хэм хэмжээтэй хослон эмэгтэйчүүд цалингүй ажил үүрэг илүүтэй гүйцэтгэхэд хүргэжээ. Энэ нь цалинтай ажил хийдэг эмэгтэй ажилчид, уламжлалын дагуу цалингүй гэрийн ажил хийдэг эмэгтэйчүүдэд илүү ачаалал нэмж, уламжлалт эрэгтэй-эмэгтэй хоорондын хөдөлмөрийн хуваарилалтын тэгш бус байдлыг улам өдөөж байна.



Үндэстний цөөнхийн хүмүүсийн талаар хүмүүс заримдаа буруу зүйлс хэлдэг... Энэ нь намайг тавгүйтүүлж, нөгөөдүүл ч ажилд авдаггүй.

(Үндэстний цөөнхийн төлөөлөл, дүрвэгч ажилчин эмэгтэй, Ханой хот)



ХАНОЙГООС ХАЙДЕРБАД ХҮРТЭЛ ТУЛГАРСАН АСУУДЛУУД

2020 оны 10 дугаар сараас 2021 оны 4 дүгээр сарын хооронд манай судалгааны баг нь Ази тивийн хөгжиж буй улсууд болох Бангладеш, Лаос, Монгол, Пакистан, Вьетнам улсын 8 хотын судалгаанд оролцогчидтой онлайнгаар, утсаар болон биечлэн ярилцлага хийсэн. Энэхүү судалгаа нь цар тахлын эхэн шатанд хүмүүс хэрхэн дасан зохицож, даван туулсан болон тэдний ирээдүйн хэтийн төлөвийг судлан үзсэн.

Лаос улсад бид тус улсын нийслэл, хоёр дахь том хот (хүн ам 120,000) болох Вентиан хот болон Луанг Прабанг мужид байх, тус улсын хойд хэсэгт байх Паксе (50,000 хүн амтай, хуучин нийслэл, ЮНЕСКО-гийн дэлхийн өвийн жагсаалтад багтсан) хот, Лаос улсын төв хэсэгт байх жижиг боловч аялал жуулчлалын төв болох Ван Виенг хотын (25,000 хүн амтай) аялал жуулчлалын салбараас ажилгүй болсон хүмүүст тулгарсан сорилтуудыг судлан үзсэн. Ярилцлагад хамрагдсан ихэнх хүмүүс нь албан бус ажил эрхлэгчид байв.

Вьетнам улсын хувьд бид тус улсын нийслэл Ханой хотын (8 сая хүн амтай) үндэсний цөөнхийн

төлөөлөл, дотоодын дүрвэгч ажилчидтай ярилцлага хийсэн. Ярилцлагад хамрагдсан бүх хүмүүс нь цар талаас өмнө нутгийн хойд хэсгийн хөдөө орон нутгаас ирж, албан бусаар тогтвортой бус, зарим тохиолдолд аюултай ажлын байрууд болох барилгын салбарт ажиллаж байжээ.

Пакистан, Бангладеш болон **Монгол** улсад цар тахлаас өмнө гэртээ болон гадуур цалинтай ажил мөн цалингүй гэрийн ажил эрхэлж байсан эмэгтэйчүүдэд тулгарсан асуудлуудыг төвлөрөн судалсан. Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүд нь нэн ядуу, бичил бизнес эрхэлдэг болон дунд давхаргын бага орлоготой, бага цалинтай ажлын тарифт орлогоос дунд хэмжээний цалингийн орлого олдог эмэгтэйчүүдийн төлөөлөл байв.

Хайдерабад хот нь ойролцоогоор 350,000 эмэгтэйчүүд, хүүхдийг үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн сүлжээндээ ажиллуулдаг Пакистан улсын гоёлын шилэн бугуйвчийн үйлдвэрлэлийн гол төв юм.¹⁰ Өмнөд Азид гоёлын бугуйвчийн хэрэглээ асар өндөр ч үйлдвэрлэл нь хүнд, цалин багатай, аюултайд тооцогддог тул бугуйвч урлаачид ядууралд өртөх эрсдэл өндөртэй байдаг. Судалгааны хүрээнд бид бугуйвч үйлдвэрлэгч 15 эмэгтэйтэй ярилцсан ба эдний зарим нь гэртээ ажилладаг, зарим нь



албан ёсоор ажилгүй, бүгд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд үл хамаарах хүмүүс байв.

Хулна хот нь (хүн ам 2.9 сая) нь Дака болон Читтатонг хотуудын дараа орох Бангладеш улсын гуравдах том хот бөгөөд энэ хотод манай судалгааны баг нь бичил бизнес эрхлэгч 16 эмэгтэйтэй ярилцлага хийсэн. Тэдний ихэнх нь гоёлын хувцас, оёдлын бизнес эрхэлдэг ба албан ёсны жижиглэн худалдааны сүлжээний нэг хэсэг байсан. Тэдний аж ахуйн нэгж нь 5- 25 ажилчинтай, үндсэндээ гэрээсээ ажлаа хийдэг ба цөөн тооны ажилчид л дэлгүүрт нь биечлэн ажилладаг байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод (1.5 сая хүн амтай) бид төр болон хувийн хэвшилд ажилладаг болон ажиллаж байсан бага насны хүүхэдтэй эхчүүдийг сонгосон болно. Судлаачдын зүгээс цалинтай ажил болон цалингүй ажлыг зохицуулах, өрх гэр дэх бусад тэгш бус байдалтай холбоотой үүсэн гарсан сорилтуудын талаар ярилцан судалсан. Ярилцлагад нарийн боовны газрын худалдагч, зочид буудлын цэвэрлэгээний ажилтан, гоо сайхны салоны эзэн, жижиг үйлдвэрлэл явуулдаг компанийн менежер, аялал жуулчлалын агентлагийн ажилтан зэрэг хүмүүс багтав.

Хэдий нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал нь ялгаатай ч бүх найман хотуудын хооронд харьцуулж болохуйц зүйлсийг судалгаагаар тогтоосон. Ярилцлагад хамрагдсан бүх хүмүүс нь КОВИД-19 цар тахалтай тэмцэхээр Засгийн газруудын авч хэрэгжүүлсэн хязгаарлалын арга хэмжээний нөлөөг гүнзгий мэдэрчээ. Энэхүү тайланд бид эдгээр нөлөөллийг судлан, дүн шинжилгээ хийсэн. Бидний зорилго нь хот суурин газрын хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэнд цар тахлаас үзүүлсэн сөрөг нөлөөллийн эсрэг илүү хүртээмжтэй, тэгш хамруулсан, иж бүрэн бодлогын хариу арга хэмжээг хэрэгжүүлж байхыг хөхиүлэн дэмжих зорилготой юм. Бид мөн КОВИД-19 цар тахлын нөлөөг ойлгохын тулд харж буй байдлаа улам өргөтгөхийг төрийн албан тушаалтнууд, хөгжлийн байгууллагуудад хандан уриалж байна. Зөвхөн эдийн засгийн үзүүлэлтээс гадна илүү олон талт, өргөн хүрээт байдлаар асуудлыг харснаар шийдвэр гаргагчид нь цар тахлаас хүний болон санхүүгийн капитал, чадамжид үзүүлж буй

нөлөөг илүү сайн тодорхойлж, хариу арга хэмжээ авах боломжтой болох юм.

5С: КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭРХ ХОТУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, КАПИТАЛ БОЛОН ЧАДАМЖ

Хэдий хийгдсэн судалгаа нь өөр өөр байршилд төвлөрөн хийгдсэн ч бүгд нэг үзэл баримтлалын хүрээг баримтлан хийгдсэн.¹¹

Судалгааны энэхүү ерөнхий үзэл баримтлал нь гурван чиглэлд төвлөрсөн ба юуны өмнө бид судалгаанд оролцогчдын амьдарч буй хотуудад КОВИД-19 цар тахлын улмаас өөрчлөгдсөн нөхцөл байдлыг судлан үзсэн. Зөвхөн эрүүл мэндэд үзүүлсэн нөлөөллөөс гадна цар тахлын үеэр Засгийн газрууд төрөл бүрийн хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлсний тоонд зай барих, сургууль болон бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох зэрэг цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах төрөл бүрийн хөтөлбөрүүд багтсан. Судлаачдын зүгээс төрийн бодлого, хөтөлбөр нь өрхийн эрх мэдлийн харилцаа, динамиктай хэрхэн огтлолцсон, олон нийтийн хандлага болон хэм хэмжээг хэрхэн өөрчилсөн, үйлчилгээний хүртээмж, ажил эрхлэлт, бизнес эрхлэх боломжид хэрхэн нөлөөлсөн зэргийг авч үзсэн.

Хоёрдугаарт бид нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөс хамааран иргэдийн биет болон биет бус нөөц (капитал) ихээхэн хэмжээгээр буурч, шавхагдсан, ялангуяа санхүүгийн капитал, нийгмийн капитал болох нийгмийн сүлжээ, хэлхээ холбоо, харилцаа, хувь хүний капитал болох мэдлэг, ур чадвар хэрхэн цар тахлын нөлөөнд өртсөн болохыг судалсан. Бидний судалгаа нь цалинтай ажил, хадгаламж болон даатгал, сэтгэцийн болон бие бялдрын эрүүл мэнд, албан бус буюу гэр бүлийн болон нийгмийн хэлхээ холбоонд үзүүлсэн нөлөөллийг мөн судлан үзсэн.

Гуравт хүмүүсийн хадгалж байсан нөөц шавхагдсан нь тэдний богино болон урт хугацаанд хүндрэлийг даван туулах чадварт сөргөөр нөлөөлсөн. Судлаачдын зүгээс энэхүү асуудлыг даван туулахад ашигласан стратегийг судалсан. Тэдний баримталсан стратегийг ирээдүйн хэтийн төлөвтэй нь холбон судлах нь хүмүүсийн чадамжид, ялангуяа ажлын байраа баталгаажуулах, албан тушаал ахих, гэр орноос гадуур хараат бус

байх зэрэг боломжид цар тахал ямар нөлөө үзүүлсэн талаарх мэдээллийг гарган өгсөн. Цар тахлаас үзүүлэх боломжит урт хугацааны нөлөөлөл нь эдгээр чадамжид үзүүлж буй нөлөөгөөр тодорхойлогдох юм.

Дүн шинжилгээний эдгээр гурван түвшин болох нөхцөл байдал, капитал болон чадамж хоорондын уялдаа холбоо нь энгийн ч бус, шугаман ч бус, нөхцөл байдал нь капитал болон чадамжид нөлөөлөх хандлагатай бол капитал болон чадамж цаашид нөхцөл байдал өөрчлөгдөхөд нөлөөлж байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЦ

Доор буй Хэсэг 2 дээр бүх найман хотын хэмжээнд судлан гаргасан үр дүнг тоймлон харуулсан. Тухайн үр дүнгүүдийг улс бүрд хийсэн судалгаануудыг холбосон үзэл баримтлалын дагуу зурагласан. Хэсэг 3 нь нөхцөл байдалд гарсан өөрчлөлтийг судалсан ба үүнд цар тахлаас үзүүлсэн эрүүл мэндийн бус нөлөөлөл, жишээ нь вирусийн тархалтыг зогсоох зорилгоор төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүнээс үүдсэн зах зээл, ажил эрхлэлтэд гарсан шок, хувь хүмүүс, бизнес эрхлэгчид болон эдийн засагт ирэх нөлөөллийг зөөллөх зорилгоор Засгийн газрын авч хэрэгжүүлсэн дэмжлэг туслалцааны арга хэмжээ зэргийг багтсан. Хэсэг 4 нь цар тахлыг тогтоон барих арга хэмжээнээс хувь хүмүүс, тэдний гэр бүлийн санхүү, хувь хүний болон нийгмийн капиталд үзүүлсэн нөлөөг судлан үзсэн. Хэсэг 5 нь эдгээр нөлөөг судлан, хүмүүсийн ирээдүйн боломж, эргэн сэргэхэд нь сөргөөр үйлчлэх урт хугацааны нөлөөллийг судлан үзсэн. Хэсэг 6 дээр судалгааны үр дүнд суурилан бодлого боловсруулагчдад зориулсан багц зөвлөмжийг тусгасан.

Судалгааны үзэл баримтлалыг эхлэл цэг болгон ашиглах замаар улс бүрийн судалгааны баг нь судалгааны асуултауд, жишиг асуулт, ярилцлагын гарын авлагыг өөрийн хамаарах улс, хотын нөхцөл байдалд нийцүүлэн бэлтгэн гаргасан. Судлаачид нь өөрийн мэдлэг дээр үндэслэн, мөн баримт бичгийн түргэвчилсэн судалгааг хийсэн нь өмнө хийгдсэн судалгаанаас орхигдсон зүйлсийг тогтоож, судалгаанд хамрагдаагүй хүн амын хэсгийг олж тогтоох боломжийг хангасан. Үүний үр дүнд хот бүрд судалгааны асуулт болон оролцогчид дээр ихээхэн хэмжээний ялгаатай байдал тогтоогдсон. Энэ нь дотоодын нөхцөл байдалд нийцсэн судалгааны санааг гарган ирэх боломжийг бүрдүүлсэн.

Хот бүр дээр судалгааны баг нь хагас бүтэцчилсэн чанарын ярилцлагыг зайнаас болон биечлэн хийсэн ба энэхүү ярилцлага хийсэн үйл явц нь тухайн улсын КОВИД-19 цар тахлын үеэр хэрэгжүүлж буй арга хэмжээнээс хамаарсан. Судлаачид нийтдээ 80 удаагийн гүнзгийрүүлсэн ярилцлагыг хийсэн ба 70 эмэгтэй, 10 эрэгтэй хамрагдсан. Эдгээр ярилцлагууд нь үндсэндээ эмэгтэйчүүдтэй хийгдсэн ба үүний зорилго нь цар тахлаас үзүүлсэн жендэрийн хамааралтай нөлөөлөл, бусад төрлийн ялгаварлах байдал, эмзэг байдлыг судлан үзсэн. Энэхүү суурь үзэл баримтлал нь улс бүрд хийгдсэн харилцан ялгаатай судалгааны үр дүнг хамтын, нэгдмэл, бүс нутгийн дүн шинжилгээ болгох боломжийг хангасан.

2. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

1

КОВИД цар тахлаас өмнө олон зах зээл **зохицуулалтгүй байсан** нь бизнес эрхлэгчид уян хатан байж, ажиллах хүчийг бага зардлаар ажиллуулах боломжийг олгож, хуулийн шаардлага бага тавигддаг байжээ. Үндсэндээ үндэстний цөөнх, дүрвэгсэд, эмэгтэйчүүдээс бүрдэх эдгээр ажилчид Засгийн газраас хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээнд бага хамрагджээ.

2

Цар тахлаас өмнө байсан **жендэрийн тэгш бус байдал** нь бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг эрчүүдтэй харьцуулбал зээл, гарааны санхүүжилтийн хүртээмжийн хувьд хэдийн хязгаарлагдмал байдалд оруулаад байжээ. Эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнес нь үндсэндээ жижиг, нөөц багатай, ихэнх тохиолдолд бүртгэлгүй байна.

3

Цар тахлаас өмнө ч байсан **жендэрийн тэгш бус байдлаас** хамааран эмэгтэйчүүд нь гэрийн болон хүүхэд асрах ажил үүргийг түлхүү хүлээж, цалинтай ажил болон бизнесийн үйл ажиллагаагаа зэрэгцүүлэн зохицуулах шаардлагатай нүүр тулжээ.

4

КОВИД-ын халдвар гарахад Засгийн газруудаас авч хэрэгжүүлсэн халдварын тархалтыг зогсоох арга хэмжээ нь **бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй болгож**, хот суурин газруудын зах зээлд хүчтэй цохилт болжээ.

5

Зах зээл нь албан бус тул урьдчилан сануулалгүйгээр **ажилчдыг ажлаас халах, ажлын цагийг нь бууруулах** явдал түгээмэл байна.

6

Орлого гэнэт тасарсны улмаас **хүмүүсийн санхүүгийн капиталд гэнэтийн сөрөг нөлөөлөл үзүүлжээ**. Үүнээс улбаалан зарим хүмүүс амьжиргааны баталгаажих түвшнээс доош орж, чухал шаардлагатай худалдан авалтынхаа хүрээнд хэцүү шийдвэр гаргах шаардлагатай болжээ.

7

Цар тахлаас өмнө **хадгаламж үүсгэх боломжгүй хэмжээнд бага орлого олж байсан** хүмүүсийн хувьд **орлого бүрэн тасарсан нь маш хүнд цохилт** болсон байна.

8

Засаг захиргааны үйл явц хүндрэлтэй, тодорхой зааварчилгаа дутмаг, бодлогыг нутгийн захиргаа буруу ойлгон хэрэгжүүлэх, бизнесүүд нь заавал бүртгэлтэй байх шаардлага тавигдсан зэрэг шалтгааны улмаас **онцгой байдлын үеийн дэмжлэг тусалцааны хөтөлбөрийн** хүртээмж хязгаарлагдмал байжээ.

9

Төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааг авах боломжгүй хүмүүсийн хувьд өөрийн **нийгэм олон нийтийн хэлхээ холбоондоо хандан тусламж хүссэн** ба гэр бүл, найз нөхдөөсөө зээл авах, шинэ ажил хайхдаа туслуулах, хүүхэд асрахад тэдний тусламжийг авах зэрэг зорилгоор ханджээ. Гэвч тэдний нийгмийн капитал нь хангалттай бус, хандаж тусламж хүсэх хэлхээ холбоо ч хүн бүрд байхгүй байжээ.


10

Хүмүүс зөвхөн КОВИД-той холбоотой бус мөн санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой **байнгын, ихээхэн стресс, бухимдалд** өртжээ.

11

Эмэгтэйчүүдэд гэрийн ажил болон хүүхэд харах үүрэг гэнэт нэмэгдэж, энэ нь ажил хийх, бизнесээ үргэлжлүүлэхтэй холбоотой сорилтуудтай хосолсон нөлөөлөл үзүүлжээ. Тэдний хувь давхар стресс, ядаргаа, бухимдалд оржээ.

АГУУЛГА



12

Эмэгтэйчүүд нь цаг хугацааны ядуурал, шилжилт хөдөлгөөний хязгаарлалт зэргээс хамааран бусдад туслах, тусламж авах боломж нь буурч, **нийгмийн харилцаа нь суларч, ганцаардсан, тусгаарлагдсан мэдрэмж нь нэмэгджээ**.

13

Хязгаарлалтууд суларсны дараа өмнөх нөхцөлдөө шууд "эргэн орох" боломжгүй байсан тул хүмүүсийн хувьд **цар тахлын дараа эргэн сэргэх нь хүндрэлтэй** байжээ.

14

Цар тахал гарахад түрээсээ төлөх, хүүхдийн сургуулийн төлбөр төлөх, хоол хүнс худалдан авах, өдөр тутмын зардлаа санхүүжүүлэхийн тулд мөнгө зээлэх, эд зүйлсээ зарах зэрэг **богино хугацааны даван туулах стратеги баримталсан нь** тэднийг санхүүгийн хувьд илүү хүндрэлд хөтлөн оруулжээ.

15

Зарим хүмүүсийн өмнө авч байсан бага боловч тодорхой хэрэглээг нь хангаж байсан цалин орлого нь буурснаар өмнө худалдан авсан зүйлийнхээ (жишээ нь мотоцикл, гар утас) **өрийг төлөх боломжгүй болсон байна**.

16

Өмнө нь эрүүл мэндийн даатгалтай байсан хүмүүс даатгалаа цуцлахаас өөр аргагүй байдалд орсон нь өвчлөх тохиолдолд маш эмзэг, хүнд нөхцөлд хүргэх болжээ.

17

Зарим эмэгтэйчүүд өөрийн **ирээдүй албан тушаал, карьерын төлөвлөгөөг тодорхойгүй хугацаагаар хойшлуулжээ**.

18

Гэр орны үүрэгт ажил нэмэгдсэн нь орлого олдог эрэгтэй болон гэрийн ажил хийдэг эмэгтэй гэсэн хуучинсаг хөдөлмөрийн хуваарийг сэргээж, **гэрийн орчноос гадуурх эмэгтэйчүүдийн ажил, амьдралын орон зайг хязгаарласан**.

19

Зарим эмэгтэйчүүдийн зүгээс өөрийн нөхрөөс санхүүгийн хувьд илүү хамааралтай болсон тухайгаа ярьж байсан.

20

Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд өрхийн шийдвэр гаргалтад оролцох, нөлөөлөл боломж багассан нь КОВИД-оос үзүүлсэн шоктой зэрэгцэн урт хугацаанд хараат бус байдал, **боломжуудаа алдахад** хүргэж байна.

3. НӨХЦӨЛ БАЙДАЛ: КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ШОКИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

2020 оны эхээр буюу КОВИД-19 анх Ази тивд анх илрэхэд олон орны Засгийн газар вирусийн тархалтаас сэргийлэн хөл хорио тогтоож, зорчих хөдөлгөөнийг хязгаарласнаар олон улсын хилийн боомт, аж ахуйн нэгжүүд, сургууль, олон нийтийн газрууд, төрийн зарим байгууллага үйл ажиллагаагаа зогсоон хаагдаж, олон хүн цугларсан арга хэмжээг бүрэн зогсоосон. Засгийн газрууд нь мөн энэхүү хатуу арга хэмжээнээс үүдэх хор хохирлыг бууруулахын тулд тусламжийн багцуудын зарлаж эхэлжээ.

ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫГ ЗОГСООХ ХҮЧИН ЧАРМАЙЛТ

Цах тахал дэлгэрсэн эхний саруудад одоогийн ашиглаж буй түргэвчилсэн тест, хавьтал хянах арга хэрэгсэл байгаагүйн улмаас Засгийн газрууд нь нийтийг хамарсан хязгаарлалтын арга хэмжээг түгээмэл хэрэгжүүлжээ. Олон улсын аяллыг зогсоохын зэрэгцээ дотоодын аяллыг хориглож, зай барих арга хэмжээг хэрэгжүүлж, эдийн засаг бизнесийн үйл ажиллагааг зөвхөн “чухал шаардлагатай ажил үйлчилгээгээр” хязгаарлах зэрэг бүхий л хэмжээг зэрэгцүүлэн хэрэгжүүлсэн. Монгол улсын дотоодод хэрэгжүүлж эхэлсэн арга хэмжээ нь ДЭМБ-аас цар тахал хэмээн зарлахаас ч өмнө 2020 оны 1 дүгээр сард эхэлсэн. Монголд хэрэгжүүлсэн арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн бүх боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох, хөлд хорио тогтоох, бизнесийн үйл ажиллагааг хязгаарлах, үүнд ресторан, музей, зочид буудал, гоо сайхны салон, үсчин болон бусад байгууллагын үйл ажиллагааг зогсоосон.

Ихэнх тохиолдолд улсын хэмжээнд авч хэрэгжүүлсэн хөл хорионы арга хэмжээ нь эдийн засагт гэнэтийн цочир шок үүсгэжээ. Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг зогсоон, хөл хорио тогтоосон нь орлого буурахад хамгийн түрүүн нөлөөлсөн бол үргэлжлүүлэн

хэрэглэгчдэд нөлөөлөн, бараа, үйлчилгээний эрэлтийг багасгажээ. Дотоод, гадаадад зорчиход хязгаарлалт тавьсан нь олон орны аялал жуулчлалын салбарт ихээхэн сөрөг нөлөөг үзүүлсэн. Лаос улсад цар тахал дэлгэрсэн эхний 6 сарын дотор жуулчдын тоо 60% буурч, 400 сая ам.долларын алдагдалд оржээ.¹² Пакистанд хурим, баяр ёслол зэрэг олон нийтийн арга хэмжээг хориглосон нь бугуйвч үйлдвэрлэл зэрэг салбарт том цохилт болжээ.

Ихэнх улсад анх харьцангуй богино хугацаагаар тавьсан хөл хориог дараа нь үргэлжлүүлэн сунгажээ. Лаос улсад гэхэд 2020 оны 3 дугаар сард эхэлсэн хөл хориог 5 дугаар сарын сүүл хүртэл үргэлжлүүлж, гадаадад зорчихыг хориглосон хорио энэхүү тайланг бэлтгэсэн 2021 оны 11 дүгээр сард ч хүчин төгөлдөр үйлчилж байна. Вьетнам улсад анх 2020 оны 4 дүгээр сарын 1- 15-ны¹³ хооронд тогтоосон улсын хэмжээний хөл хориог Ханой хот болон халдварын тархалт өндөртэй мужуудад 4 дүгээр сарын 30-ныг хүртэл сунгажээ.¹⁴

2020 оны сүүлээр эдийн засгийг хэсэгчлэн сэргээхийн тулд улс орнууд нь өөрийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг орон нутгийн халдварын цар хүрээ, Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдуулж эхэлжээ. Жишээ нь Пакистан улсад 2020 оны 3 дугаар сард бүрэн хэмжээний хөл хорио тогтоосны дараа үүнийг цуцлан, вирусийн халуун цэгүүдэд төвлөрсөн “ухаалаг хөл хориог” хэрэгжүүлсэн байна.¹⁵

Хөл хорионы эдгээр хэлбэрүүд нь Ази тивийн хэмжээнд олон сая хүний бизнесийн болон хувийн эдийн засгийн байдалд асар их сөрөг нөлөөлөл үзүүлж, тэр дундаа хамгийн бага орлоготой хэсэгт хүндээр тусжээ. Жишээ нь эмзэг бүлэгт хамаарах Вьетнамын үндэстний цөөнхийн орлого цар тахлын эхний саруудад 75%-иар буурсан байна.¹⁶

АЖ АХУЙН НЭГЖ, ХУВЬ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН ТӨРИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ СХЕМ

2020 оны 4 дүгээр сар гэхэд судалгаанд хамрагдсан 5 улсын Засгийн газар нь цар тахлаас эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг хөнгөлөх зорилго бүхий багц хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү санхүүгийн тусламжид эдийн засгийн гол салбаруудад зээл олгох, татвар бууруулах, өрийг хөнгөлөх зэрэг арга хэмжээг багтаасан. Засгийн газрууд нь мөн бэлэн мөнгө олгох болох татвар хөнгөлөх замаар иргэдийн алдагдсан орлогыг нөхөхийн зэрэгцээ уян хатан ажлын цаг баримтлахыг үүрэг болгожээ. КОВИД-19 цар тахлаас үүдсэн олон тооны эдийн засгийн асуудлууд нь хот суурин газар дотор суурилсан байдлаар илэрч байсан ч дэмжин туслах тогтолцоо нь үндсэндээ төрийн олон түвшнээс гарч хэрэгжсэн. Ихэнх тохиолдолд эдгээр бодлогыг үндэсний хэмжээнд боловсруулж, яамдын харьяаны орон нутгийн хүнд сурталт бүтцээр дамжин хэрэгжсэн байна. Ерөнхийд нь хэлбэл КОВИД-19 цар тахлын эрүүл мэнд, нийгэм-эдийн засгийн чиглэлийн дэмжлэг тусалцааг боловсруулан гаргахад тухайн тусалцаа нь хотын иргэдэд хамаарах ч хотуудын эрх баригчдын үүрэг роль хязгаарлагдмал байж, харин хотууд нь төрөл бүрийн хэлбэрийн дэмжлэг тусалцааг зохицуулах, түгээх зэрэг үүргийг гүйцэтгэжээ.

Монгол улсад ажлын уян хатан цагийг хэрэгжүүлсний зэрэгцээ Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын зүгээс хувийн хэвшилд ажиллаж буй эцэг эх, асран хамгаалагч нарт, үүнд хүүхэд нь өвдсөн бол нэмэлт чөлөө олгохыг ажил олгогч нарт уриалан ажиллажээ. Засгийн газрын зүгээс сургуулиудын үйл ажиллагааг зогсоосноор сар тутмын хүүхдийн мөнгөн тэтгэмж болон бусад нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний эрхийн бичиг тараажээ. Мөн Монгол улс нь хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгожээ.

Вьетнам улсын хувьд Засгийн газраас ажил олгогч нарын ажилчдынхаа цалинг төлөхөд зориулсан тэг хувийн хүүтэй зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг эхлүүлсэн. Засгийн газар нь мөн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, цахилгааны үнийг

бууруулж, аж ахуйн нэгжүүдийн зээлийн өрийг багасгаж, банкнуудад зориулсан зээлийн багцыг гаргасан.¹⁷ Үүний зэрэгцээ нийгмийн хамгааллын хоёр багц хөтөлбөр гаргасны тоонд “26 их наяд донгийн хөтөлбөр” (2021 оны 7 дугаар сар) болон “38 их наяд донгийн хөтөлбөр” (2021 оны 10 дугаар сар) хэмээн нэрлэжээ. Сүүлийн хөтөлбөрт нь ажилгүй, албан бус ажилчдыг тус улсын түүхэнд анх удаа хамруулсан бол эхний хөтөлбөрт албан бус салбараас ажилгүй болсон хүмүүсийг хамруулжээ. Мөн Засгийн газрын зүгээс “62 их наяд донгийн хөтөлбөр” (2.6 тэрбум доллар) хэмээх нийгмийн хамгааллын багцыг хэрэгжүүлэн цар тахлаас бусад эмзэг бүлэгт учруулсан нөлөөллийг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлжээ.¹⁸

2020 оны 3 дугаар сард Пакистан улсын Засгийн газар 1.2 их наяд Пакистан рупитэй тэнцэх (ойролцоогоор 7 тэрбум ам.доллар) эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг эхлүүлж, улмаар 100 тэрбум (579 сая ам.доллар) рупийг “Онцгой байдлын тусламжийн санд” хуваарилжээ. Эдгээр багц арга хэмжээ нь төрөөс үзүүлж буй дэмжин туслах хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүст мөнгөн тусламж үзүүлэх, мөн 4 сарын хугацаанд зарим өрхүүдэд нэмэлт мөнгөн тусламж олгожээ. Засгийн газраас мөн 200 сая рупитэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг албан ёсны аж үйлдвэрийн салбараас халагдаж, өдрөөр цалинждаг ажил хийж буй хүмүүст зориулан баталсан. Эдгээр арга хэмжээнд мөн нэн шаардлагатай хүнсний зүйлсээр хангах, татвар нөхөн олгох, татварын хувь хэмжээг бууруулах (ялангуяа хүнсний зүйл дээр) зэрэг арга хэмжээг нэмэлтээр авчээ.¹⁹ 2020 оны 4 дүгээр сард Засгийн газраас Ehsaas (Эхсаас)²⁰ хэмээх (Онцгой үеийн мөнгөн тусламжийн хөтөлбөр²¹) хэрэгжүүлж, ядуурлын баталгаажих түвшнээс доор амьдарч буй 12 сая өрхөд тусгайлан мөнгөн тусламж үзүүлжээ.²²

2020 оны 4 дүгээр сард Бангладешийн Засгийн газраас цар тахлын эхний саруудад учирсан эдийн засгийн алдагдлыг нөхөх зорилгоор 727.5 сая такагийн (8.573 тэрбум ам.доллар буюу тус улсын ДНБ-ны бараг 2.5%-тай тэнцэх) эдийн засгийг сэргээх 4 багц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зарласан. 2020 оны 3- 10 дугаар саруудад Засгийн газраас 200 их наяд такагийн (2.35 тэрбум ам.доллар) өртөг бүхий эдийн засаг сэргээх багц хөтөлбөрийг жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулан гаргасан. Үүний дараа 300 тэрбум такагийн (34.9 тэрбум ам. доллар) өөр нэгэн хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сард хэрэгжүүлж эхэлжээ.²³

Лаос улсын Засгийн газар нь цар тахлын үеэр өрхийн хэрэглээг дэмжих зорилгоор татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд сар тутам 5 сая кипээс (550 ам.доллар) доогуур орлого бүхий өрхүүдийг орлогын албан татвараас чөлөөлсөн. Засгийн газраас мөн цахилгаан, ус, хог хаягдал, интернэтийн төлбөрийг гурван сарын хугацаанд чөлөөлж, импортын тарифыг тэглэжээ. Түүнчлэн арга хэмжээний хүрээнд жижиг, дунд бизнесийн салбарыг санхүүжүүлэх зорилгоор зээл олгожээ. Хувь хүн, өрхүүдэд олгосон шууд дэмжлэг нь маск болон гар ариутгагч зэрэг хамгаалах хэрэгсэл тараахаар л хязгаарлагджээ.²⁴



Торго нэхэж буй эмэгтэй. Лаос улс, Луанг Прабанг, Зургийг: Def-anan

4. КАПИТАЛ: АНХДАГЧ НӨЛӨӨЛӨЛ

Бидний судалгаагаа нь КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор зорчих хөдөлгөөн хязгаарласан явдал, зах зээлд үүссэн шок нь хот суурин газрын хүн амд хэд хэдэн шууд сөрөг нөлөөг бий болгосныг харуулж байна. Эдгээр нь өмнө бодитоор байсан тэгш бус байдлыг улам даамжруулж, Засгийн газраас үзүүлж буй дэмжлэг туслалцаа нь хот суурин газрын оршин суугчдын эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдлыг хангахад үр дүн багатай буйг харуулжээ.

САНХҮҮГИЙН КАПИТАЛ: ОРЛОГО БОЛОН ҮР ӨГӨӨЖ

Судалгаанд хамруулсан бүх найман хот нь цар тахлаас үүссэн санхүүгийн сөрөг нөлөөллийг мэдэрчээ. Олон хүмүүс санхүүгийн капитал нь маш хурдан буурч, шавхагдах аюултай тулгарсан байна. Жишээ нь цар тахлаас өмнө хувийн хэвшилд ажиллаж байсан Улаанбаатар хотын дунд орлоготой эмэгтэй цар тахал эхлэхэд орлого нь бүрэн зогссон талаар дурдаж байв. Энэ явдал нь хязгаарлалтын арга хэмжээнээс үүдэн ажилгүй болсон эсвэл бизнесийн байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсноос шалтгаалжээ. Олон тооны бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулах цагаа бууруулах эсвэл бүр зогсоох шаардлагатай болжээ.

Хулна хотод бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөл хорио нь гинжин урвалаар нөлөөлсөн талаар тайлбарлаж байв. Дэлгүүр, бизнесийн байгууллага, захууд хаагдсанаар олон тооны бизнес эрхлэгчийн зүгээс орлого буурсан, захиалга багассан хэмээн үзэж байна. Борлуулалт буурснаар бизнес эрхлэгчдийн орлого огцом унаж, гэр бүлийн орлогыг дангаар олдог эсвэл томоохон хувь нэмэр оруулдаг эдгээр хүмүүсийн гэр бүлийнх нь санхүүд маш сөрөг нөлөө үзүүлжээ. Ярилцлагад оролцсон олон хүмүүсийн хувьд ажилчдаа халах эсвэл цалинг нь бууруулах шаардлага үүсжээ. Зарим бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хэлснээр хотод үүссэн санхүүгийн хүндрэлээс шалтгаалан ажилчдынх нь дийлэнх нь буцаж тосгондоо очихоос өөр сонголтгүй болжээ.

Лаос улсад Вьентиан, Паксе, Луанг Прабанг болон Ван Виенг хотуудын аялал жуулчлалын салбар мөн ижил хүндрэлтэй тулжээ. Зарим оролцогчид орлого нь гэнэт тасарсан нь тэднийг ядууралд түлхсэн хэмээн үзэж байна. Жишээ нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг жолооч хэлэхдээ өмнө нь тэрээр 1,500,000 кипийн (ойролцоогоор 157 ам.доллар) орлого олдог байсан бол одоо энэ хэмжээ 750,000 кип болж (ойролцоогоор 79 ам.доллар) болж буурсан нь сарын доод цалин болох 110 ам.доллароос ч бага байна. Олон тохиолдолд орлого буурсан явдал болон санхүүгийн шок нь цар тахлын эхний үеэс, бүр хөл хорио тавигдах, үйл ажиллагааг хязгаарлахаас ч өмнө тулгарч эхэлжээ. Хөл хорио нь энэхүү санхүүгийн хямралыг улам гүнзгийрүүлжээ.

Ханой хотын үндэстний цөөнхийн бүрдүүлдэг дотоодын дүрвэгч ажилчидтай хийсэн ярилцлагаар богино хугацаанд тавьсан хөл хорио нь сөрөг нөлөөлөл ихээр үүсгэсэн болохын тогтоосон. Засгийн газраас зарласан эхний нэг сарын хугацаатай хөл хорио нь үндэстний цөөнх ажилчдад нэн даруй цочир шок үүсгэжээ. Энэ явдал мөн гэнэт хөл хорио тавьсан Хайдерабад хотод ч ижил нөлөө үзүүлж, үйлдвэрүүд хаагдаж, гоёлын бугуйвч үйлдвэрлэдэг эмэгтэйчүүд хэдэн сарын туршид ажилгүй байжээ. Тэдний ихэнх нь өмнө нь ажиллаж байсан үйлдвэрээс ямар нэгэн дэмжлэг туслалцаа аваагүй байна.



Тэд [засгийн газар] хэлэхдээ энэ нь [тусламж] нь зөвхөн хөдөлмөрийн гэрээ бүхий ажилчдад зориулсан гэсэн."

(Үндэстний цөөнхийн төлөөлөл, дүрвэгч ажилчин эмэгтэй, Ханой хот)





Эхэн үедээ нөхцөл байдал үнэхээр хүнд байсан. Үйлдвэрүүд хаагдсан, бид цалингүй болсон... Үйлдвэрүүд эргээд 10-12 дугаар сард нээгдэж ажилласан ч буцаад 1 дүгээр сард хаагдсан. Одоо эргэж хэзээ нээгдэх нь тодорхойгүй байна. Ажилгүй зогссон өдрүүдийн цалин байхгүй."

(Гоёлын бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэй, Хайдерабад)



Тухайн үед хязгаарлалт тогтоосон байсан тул би гэрээс гарч чадаагүй. Миний бизнес бүрэн хаагдсан."

(Оёдолчин эмэгтэй, Хулна)



Хулна хотын бичиг бизнес эрхлэгч олон тооны эмэгтэй шаардлагатай бараа, материал нөөцлөх, хүлээгдэж буй захиалгаа дуусгах, ажилчдаа бэлтгэх зэрэг хөл хорионоос үүдэн санхүүгийн нөлөөлөлд бэлдэх цаг байгаагүй хэмээжээ. Тэдний олонх нь бизнесийн үйл ажиллагааг хүчээр зогсоосны дараа эргэн сэргээхэд ихээхэн хүндрэлтэй нүүр тулжээ. Ялангуяа олон эмэгтэйчүүд үйлчлүүлэгч нартайгаа уулзах, түүхий эд худалдан авах, өөрийн танилууд болон бусад хэлхээ холбоо бүхий хүмүүсээс тусламж хүсэх, бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх сонголтод арга замыг эрэлхийлэх боломжгүй байсныг цохон дурдсан. Өмнө хэвшиж тогтсон жендэрийн тэгш бус байдлаас хамааран эдгээр бизнес эрхлэгч эмэгтэйчүүд гарааны бизнес байдлаар эхэлж, капитал хөрөнгө багатай, зээлийн хүртээмж хязгаартай үйл ажиллагаа явуулж байсан тул бизнесийнх нь хэмжээ жижиг, албан ёсны бүртгэлгүй, капиталын нөөц бага байжээ.

Үндсэн хэрэглээний зардлаа хасах нь

Зарим тохиолдолд цар тахлын санхүүгийн нөлөө нь айл өрхүүдийн хоол хүнс зэрэг үндсэн хэрэгцээгээ хангах боломжид сөргөөр нөлөөлжээ. Улаанбаатар

хотоос оролцогчид шаардлагатай зүйлсэд зарцуулах зардал мөнгөө хэмнэж эхэлсэн талаар дурдсан. Ажил, орлогогүй болсон хүмүүсийн хувьд таналт илүү хийгдсэн ч ажлын байртай хүмүүс ч зарцуулалтаа багасгаж, хадгаламжаа нэмж байсан нь гэрээсээ ажиллахтай холбоотой нэмэлт зардлаа зохицуулах эсвэл ирээдүйд гарч болох алдагдлаас хамгаалах зорилготой хийгджээ.

Хайдерабад хотод ярилцлагад хамрагдсан хүмүүс нь түрээс төлөх, хүүхдийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдан авах эсвэл эм худалдан авахын дунд сонголт хийх шаардлагатай тулгарчээ. Гэр бүлийнхээ хэрэгцээт зүйлсийг хангахын тулд олон эмэгтэй өөрсдийн хувийн хэрэгцээг хойш тавьжээ. Үүний нэгэн адил Лаос улсын 4 хотын оролцогчид ч ямар зүйлийг нь тэргүүн эгнээд тавихтай холбоотой хүнд шийдвэр гаргах шаардлагатай болжээ. Тэд шампунь зэрэг шаардлагатай зүйлсээ бага хэмжээгээр худалдан авч, хэрэглээний аль төлбөрөө төлөлгүй үлдээх талаар шийдвэр гаргаж, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн зардлаа танажээ. Зарим хүмүүсийн хувьд мөн иддэг хоол хүнсний төрлөө өөрчилж, сүү, жимс, мах хэрэглэхээ зогсоож, бусад хоол хүнсний бүтээгдэхүүн эрэлхийлж эхэлжээ. Ханой хотын үндэстний цөөнх ажилчид амь үлдэхийн тулд боломжтой хэмжээнд хүртэл өрхийн зардлаа бууруулж, эхний хөл хорионы 30 хоногт гоймон, будаа л идэж байв.

Улаанбаатар хотын хувьд цар тахлын эхний шатанд ажлын байртайгаа үлдсэн ажилчид ч санхүүгийн хувьд хүндрэл үүссэн хэмээн мэдээлж байв. Ялангуяа төрийн албан хаагчдын зүгээс гэртээ ажиллаж байх үед утсаараа албаны яриа хийх нь огцом нэмэгдсэнээс үүдэн нэмэлт зардал гарсан тухай хэлж байна.

Төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааг авахад тулгарсан хүндрэл

Бангладеш, Монгол, Пакистан, Вьетнам улсуудын олон оролцогчийн зүгээс Засгийн газраас авч хэрэгжүүлсэн тусламжийн арга хэмжээний талаар сайн мэдлэгтэй байна.²⁵ Төрөөс хэрэгжүүлсэн зарим эерэг үр дүн бүхий арга хэмжээнээс бусдаар оролцогчид тухайн арга хэмжээ нь бодит байдал дээр үр дүн багатай, зөвхөн тодорхой багц хэрэгцээг л харгалзан хэрэгжүүлсэн арга хэмжээ гэж үзжээ.



Интернэт байхгүй, гар утасны дата авах мөнгө байхгүй бол заримдаа гэртээ ажиллах боломжгүй тул ажил дээрээ очихоос өөр сонголт байхгүй.

(Их сургуулийн багш эмэгтэй, Улаанбаатар)



Саяхан Ковид-19 цар тахал гараад л бид өдөр тутам ажиллах болсон. Өдөр шөнөгүй 24 цагаар ажилласан. Дуудсан тохиолдолд шууд гарахаар байнгын бэлэн байдалд байсан. 24 цаг ажилласны дараа жоохон амраад эргээд бүтэн өдөр эргүүлд гардаг байсан. Өдөр нь гудамжаар эргүүл хийгээд дараа өдөр нь дахиад л 24 цаг ажиллаж байсан.”

(Төрийн албан хаагч эмэгтэй, Улаанбаатар)



Улаанбаатар хотод гэхэд ихэнх төрийн албан хаагчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагджээ. Жижиг бизнес эрхлэгч гэх мэт хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд цар тахлаас өмнө ямар нэгэн татвар төлдөггүй байсан тул татварын хөнгөлөлт тэдний хувьд хамааралгүй байжээ. Төрийн албан хаагчдын зүгээс уян хатан ажиллах сонголтгүйгээр ажлын ачаалал нь нэмэгдсэн болохыг дурдсан. Ханой хотод гэхэд ярилцлагад оролцсон хүмүүсийн дийлэнх нь 61 их наяд донгийн тусламжийн хөтөлбөрийн талаар ам дамжсан ярианаас, радиогоор, олон нийтийн мэдээлэл (олон нийтийн газарт байрлуулсан чанга яригч) эсвэл орон нутгийн захиргаанаас сонсож мэджээ.²⁶ Гэвч оролцогчдын хувьд энэхүү засаг захиргааны ээдрээтэй үйл явц, тодорхой мэдээлэл, зааварчилгаа хангалтгүй байдал, төрийн хэрэгжүүлсэн тусламжийн арга хэмжээний хүртээмж хангалтгүй байсан нь захиргааны ээдрээ бүхий үйл явц, тодорхой мэдээллийн хомсдол (үүнд орлого нь ядуурлын баталгаажих түвшнээс доош

болохыг хэрхэн нотлох гэх мэт), оршин суух баримт бичиггүй байдал, орон нутгийн зүгээс бодлогыг буруугаар ойлгон хэрэглэх байдал зэрэгтэй зэрэгцэн тусламжийн хүртээмжийг бууруулжээ.

Хайдерабад хотод Засгийн газрын хэрэгжүүлсэн тусламжийн хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй байсан цөөн тооны бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэйн зүгээс хөтөлбөрт хамрагдах бүртгэл, журам нь тодорхойгүй, ээдрээтэй байсныг дурдаж байв. Тухайн эмэгтэйчүүдийн бичиг үсэгт тайлагдсан байдал бага тул тусламж дэмжлэг авахад нь ноцтой хүндрэл үүсгэсний зэрэгцээ гэрийн ажлын улмаас чөлөөт цаг бага байдаг нь мөн нөлөөлжээ. Түүнчлэн Ehsaas хөтөлбөр нь санхүүгийн тусламж авахын тулд иргэний үнэмлэхийн дугаар шаарддаг бүртгэлийн системтэй байжээ. Ярилцлагад хамрагдсан бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийн дийлэнх нь иргэний үнэмлэхгүй тул тусламж авч чадаагүй ажээ. Эмэгтэйчүүдийн зорчих хөдөлгөөнд тулгарч буй нийгмийн хязгаарлалт нь төрөөс олгож буй дэмжлэгийг авахын тулд гэрээс гарахад нь саад болж байжээ. Зарим эмэгтэйчүүдийн зүгээс Засгийн газар болон эрх баригчдад итгэдэггүй болохоо илэрхийлж байв. Тогтмол болон хийснээрээ цалинждаг хүмүүс, ядуурлын баталгаажих түвшнээс доор амьдарч буй хүмүүст зориулсан тусламжийн хөтөлбөр ч мөн л хамрагдахад хүндрэлтэй байжээ. Гэр бүлийн нэр төр, тусламжийн хэрэгцээний талаарх сөрөг үзэл бодол нь мөн эмэгтэйчүүдийн дэмжлэг авах боломж, тусламжийн хүртээмжид нөлөөлжээ.



Тиймээ, Засгийн газрын хэрэгжүүлж буй тусламжийн хөтөлбөрийн талаар бид сонссон. Тусламж авахаар хэд хэдэн удаа очсон ч бидэнд өгөөгүй. Би иргэний үнэмлэхээ үзүүлсэн ч хувилж авчаад надад юу ч өгөөгүй.”

(Хайдерабад хотын бугуйвч урлаач эмэгтэй)



Хулна хотын ихэнх бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн бизнесээ албан ёсны зөвшөөрөл, бүртгэлгүй, банкны дансгүй эрхэлдэг тул Засгийн газрын зүгээс бизнесийг дэмжих зорилгоор үзүүлсэн тусламж дэмжлэгт хамрагдаагүй ажээ. Зээлийн эргэн төлөлтийн нөхцөл тааруу, хүүгийн хувь хэмжээ өндөр, банк/санхүүгийн байгууллагуудын зүгээс олон тооны баримт бичиг шаарддаг зэргээс шалтгаалан Засгийн газрын тусламжийн хөтөлбөрт хамрагдах сонирхол нь буурчээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүд зээл авахад илүү хүнд байсан шалтгаан нь зээлийн эргэн төлөлт хийхэд ямар нэгэн дэмжлэг байхгүй, өрх толгойлсон статусаас нь шалтгаалж байжээ.

Ерөнхийд нь үзвэл тухайн улс орнуудын Засгийн газар нь ард иргэддээ дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн ч хамаарах дүрэм журам нь хэт ээдрээ, төвөгтэй, заавал интернэтийн хүртээмжтэй байх, гар утастай байх, бичиг үсгийн болон цахим хэрэглээний ур чадвартай байхыг шаардаж байжээ. Харин эдгээр нь ядуу, орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийн хувьд хүртээмж нь хязгаарлагдмал тоног төхөөрөмж, ур чадвар юм. Бидний судалгаагаар ард иргэдэд мэдээлэл хүргэх үйл явцыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс шалтгаалан маш олон хүн Засгийн газраас үзүүлж буй тусламжийн гадуур үлджээ. Түүнчлэн дүрэм журам хурдан өөрчлөгдөж, хөл хорионы арга хэмжээ авч эхэлсэн нь тусламжийн хөтөлбөрийн талаар ойлголт мэдээлэл авах, хөтөлбөрт хамрагдахад нь илүү хүндрэл үүсгэжээ. Үүний зэрэгцээ хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ өгөхийн тулд агааржуулалтгүй орчинд дараалалд удаан зогсох зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц эрсдэл мөн тулгарсан байна.

Өмнө оршиж байсан эмзэг байдлын үзүүлсэн нөлөө, үүрэг

Цар тахлаас ч өмнө хэдийн бий болоод байсан тэгш бус байдал нь хөл хорионоос үүдэх сөрөг нөлөөлөл, иргэдийн санхүүгийн капиталын хомсдолыг улам нэмэгдүүлжээ. Ханой хотод хамгийн анхны хөл хорионоос үүдсэн санхүүгийн нөлөө өндөр, бага хадгаламжтай эсвэл огт хадгаламжгүй хүмүүсийн хувьд уналт болж, үүнд үндэстний цөөнхөөс бүрдэх цагаач ажилчид ихээр өртжээ. Нөгөө талаар олон ажилчид цар тахлаас өмнө аман эсвэл харилцан итгэлцэлд

суурилсан гэрээгээр, ямар нэгэн нэмэлт тэтгэмж, албан ёсны эрхгүй ажиллаж байжээ. Энэ нь хөл хорио тогтоосон өдрөөс эхлээд л тэд цалин орлогогүй болсон гэсэн үг юм. Нийгмийн хамгааллын арга хэмжээ хомс байсан нь цагаач ажилчид хотыг орхиж, тосгондоо буцахад хүргэжээ.

Пакистан улсад албан бус салбар нь хөдөө аж ахуйн бус салбарын хөдөлмөр эрхлэлтийн 72%-ийг бүрдүүлж, хот суурин газрын хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн 67%-ийг ажиллуулж байдаг.²⁷ Энэ салбарын ажилтнууд нь цар тахал дэгдэхээс ч өмнө хөдөлмөрийн хуулийн хамгаалалтгүй, төрөөс ч дэмжлэг багатай байжээ.²⁸ Хөл хорио нь бидний ярилцлага хийсэн ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлсэн ба өмнө нь ч дунджаас доош орлого олж байсан бугуйвч урлаач эмэгтэйчүүд илүү хүндрэлд өртжээ. Тэд цалин орлогогүй, цалинтай чөлөөгүй хоцорч, ажил олгогчдын зүгээс ямар ч дэмжлэг аваагүй байна. Эмэгтэйчүүдийн хамгийн ихээр хэлж байсан зүйлс үйлдвэр хаагдсанаас хойш нэлээд олон сарын туршид ажилгүй байжээ. Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүд, ялангуяа ихэнх нь бичиг үсэггүй эмэгтэйчүүдийн хувьд гар утасгүй, интернэтгүй улмаас, оршин суух бүртгэлгүйн улмаас Засгийн газраас ямар нэгэн дэмжлэг авч чадаагүй.

Дээрхийн нэгэн адил Лаос улсын аялал жуулчлалын гол хотуудаас судалгаанд хамрагдсан хүмүүсийн ч цар тахлаас үүдэн ихээхэн хохирол амсжээ. 2020 оны 2 дугаар сарын төгсгөлд аялал жуулчлалын хөтөч, энэ чиглэлээр ажилладаг хүмүүс ажилгүй болжээ. Ярилцлагад хамрагдсан ихэнх хүмүүсийн хувьд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаагүй байжээ.

ХҮНИЙ КАПИТАЛ: СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД, САЙН САЙХАН БАЙДАЛ



Хүндрэл, стресс, уйтгар гунигаар дүүрэн хугацаа л байсан."

(Оёдолчин эмэгтэй, Хулна)



Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн зүгээс цар тахлаас үүдэн тэдний санхүүгийн капиталд үзүүлсэн нөлөөлөл

болон сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлсэн нөлөөллийг шууд холбоотой хэмээн үзэж байв. Ханой хотод хийсэн судалгаагаар үндэстний цөөнхийн бүрдүүлдэг ажилчдын зүгээс өөрт тулгарсан стресс, цөхрөл болон орлого нь гэнэт тасалдсанаас үүдэн үүдсэн итгэл алдсан байдлын талаар ярьж байв. Хайдерабад хотын бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийн зүгээс байнга л мөнгөний асуудлаар санаа зовниж байснаа ярьж байсан. Хулна хотын ярилцлагад хамрагдсан хүмүүсийн зүгээс өөрсдийн болон гэр бүлийнхний сэтгэц, бие бялдрын эрүүл мэндэд цар тахлаас үзүүлсэн нөлөөллийн талаар ярьж тэдний сайн сайхан байдал буурсан талаар нийтлэгээр хүлээн зөвшөөрч байв. Нэг оролцогчийн зүгээс цар тахлын үеийн хүндрэл, стресс, гуниг зэрэг ямар байдалтай байсныг дурсаж байсан. Жижиг бизнес эрхлэгч олон хүний зүгээс өөрийн санхүүгийн нөхцөл байдал, ирээдүйн талаар маш их сэтгэл зовж байснаа дурссан. Сэтгэл санааны хувьд хүндрэлд орох улмаар бие бялдрын хувьд муудахад хүргэж байжээ.



Өмнө нь би хамаагүй эрүүл харагддаг байсан, харин одоо бол 9 кг алдсан. Миний массажны бизнес ч олигтой явахаа больсон, үйлчлүүлэгч цөөхөн ирдэг болсон. Дараагийн 5 жилд юу хийхээ л бодож байна. Тэр ч байтугай шөнө ч сайн унтаж чадахаа больсон.

(Аяллын хөтөч эмэгтэй, Луанг Прабанг)



Хулна хотод бидний хийсэн судалгаагаар гэр бүлээ асран тэтгэх үүрэг хариуцлага нэмэгдсэн нь эмэгтэйчүүдийн хувьд ихээхэн дарамт үүсгэж, тэднийг эцэж цуцахад хүргэжээ. Хүүхдэдээ гэрээ нь хичээл заах зэрэг гэр орны нэмэлт ажил үүрэг хийх болсон, гэр бүлийнхээ хэрэгцээт зүйлсийг бүрэн хангаж чадахгүй буйдаа өөрийгөө буруутгаж байсан гэдгээ эмэгтэйчүүд илэрхийлж байв. Үүн дээр нэмээд гэр бүлийн гишүүдийнхээ эрүүл мэнд, сайн сайхан байдалд санаа зовох нь илүүтэй нэмэгджээ. Сургуулиуд хаагдаж, ганцаардаж, эмзэг байдалд орсон бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хэрэгцээт зүйлсээ хангах, гэр орноо авч явахын тулд бизнесээ үргэлжлүүлэхийн тулд тулгарсан дарамт шахалтын талаар ярьцгааж байв.



Бидний нэгэн адил эмэгтэй бизнес эрхлэгчид гэр бүлээ авч явах, бизнесээ үргэлжлүүлэх шаардлагатай болсон. Бидэнд санхүүгийн болон сэтгэлзүйн дэмжлэг хэрэгтэй байна.

(Бизнес эрхлэгч эмэгтэй, Хулна)



*Бугуйвч хийж буй эмэгтэй, Хайдерабад
2015 Зургийн Marvi Soomro. dawn.com*



Дээрхийн нэгэн адил Улаанбаатар хотын төрийн албан хаагч эмэгтэйчүүд ажлын ачаалал их хэмжээгээр нэмэгдсэн гэж үзсэн ба энэ нь Засгийн газар болон орон нутгаас тавьсан хөл хориог хэрэгжүүлэхэд зориулан олон хүн цуглахаас сэргийлэн хянах, ариутгал цэвэрлэгээ хийх зэрэг ажилд дайчлагдсантай холбоотой байна. Хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүд өөрийн ажлаа хийхийн зэрэгцээ ажлаас халагдсан бусад хүмүүсийн ажлыг нөхөж хийхийн тулд ихээхэн дарамттай ажилласнаа илэрхийлсэн. Цар тахлаас үүдэн ядарч, цуцсаны дээр эмэгтэйчүүд мөн хүүхдэдээ илүү цаг зарцуулах боломжгүй байсандаа өөрсдийгөө ихээхэн буруутгаж байна. Зарим эмэгтэйчүүдийн хувьд эхчүүд ажлаас илүү хүүхдээ анхаарах ёстой гэж бусад хүмүүсийн зүгээс шахалт үзүүлдэг нь мөн л асуудал болжээ.



**Би үйлдвэрт ажиллаж байсан
Хүнд ажилтай, тэнд халуун, гал
түймэр, хагархай шил гээд л хүн
гэмтээж болох зүйл ихтэй. Би
одоо нас хөгширч, ажил хийхэд
хэцүү болсон ч өөр арга байхгүй,
бүх зүйлээ өөрөө л анхаарах
шаардлагатай байна.
(Хайдерабад хотын бугуйвч
үйлдвэрлэгч эмэгтэй)**



НИЙГМИЙН КАПИТАЛ: ХЭЛХЭЭ ХОЛБОО БОЛОН АЛБАН БУС ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА

Бидний судалгаа нь цар тахлаас нийгмийн капиталд үзүүлсэн ноцтой нөлөөллийг тусган харуулсан ба үүнд иргэдийн нийгмийн капиталын нөөц болон цар тахлын даван туулах боломж хоорондын хамаарлыг тусган харуулсан. Цар тахлаас үзүүлсэн хамгийн эхний нөлөө нь эмэгтэйчүүдийн хувьд цаг хугацаа, шилжилт хөдөлгөөн хязгаарлагдаж бусдад туслах, бусдаас тусламж авах боломж нь буурч, нийгмийн харилцааг сулруулж, цөхрөх, аюулгүй байдалдаа санаа зовох байдлыг нь улам нэмэгдүүлжээ.

Хулна хотын бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд нийгмийн чиглэлээр дэмжлэг тусалцаа хомс

байсан нь тэдэнд илүү их стресс үүсгэж, бусдаас тусгаарлагдмал байх мэдрэмжийг нэмэгдүүлжээ. Улаанбаатар хотын хувьд гэрээс гадуур ажил эрхэлдэг, цаг зав багатай эмэгтэйчүүдийн хувьд нийгмийн харилцаанд орох нь огцом буурчээ. Хүүхдэдээ вирус халдаана хэмээн хөршүүд, найз нар нь айсны улмаас хүүхэд харах сонголт улам хязгаарлагдмал болжээ. Үүний улмаас олон гэр бүл хүүхдээ харж хандах хүнгүй орхиж, ялангуяа ажлын ачаалал ихтэй төрийн албан хаагчдын хувьд нөхцөл байдал илүү хүнд байв. Нийслэл Улаанбаатар хотын ажил эрхэлдэг эхчүүд хүүхдээ хэн нэгнээр, ихэнхдээ эмээ зэрэг өндөр настай хамаатныхаа нэгээр харуулах шаардлагатай байдаг. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн хувьд ч энэ сонголтоос тойрч гарах боломжгүй байдаг ажээ. Ялангуяа тухайн өндөр настай хамаатан садан нь хүүхэд харах боломжгүй болох тохиолдолд яаж ажлаа хийх вэ гэдэг нь тэдний хувьд асуудал болдог байна.

Лаос улсын Паксе, Луанг Прабанг болон Ванг Виен хотуудын хийсэн хэд хэдэн ярилцлагаар санхүүгийн байдал хязгаартай байсан нь гэр бүл, найз нарын хамтаар нийгмийн харилцаанд оролцох боломжийг нь хязгаарласан болохыг тогтоосон. Хулна хотын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн үйлчлүүлэгч, харилцагчидтай байнга харилцаж байх боломж хаагдаж, харилцаа үүсгэх, бизнесээ өргөтгөх боломж хаагдсанд ихээхэн харамсаж байв.

Харин цар тахлаас үүдсэн цөөн тооны эерэг нөлөөллийн хувьд энэ үеэр гэр бүлийн харилцаа илүү бэх бат болжээ. Хулна хотын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд гэр бүлтэйгээ илүү их цаг зарцуулсандаа баяртай буйгаа илэрхийлсэн. Үүний нэгэн адил Улаанбаатар хотод ч эмэгтэйчүүд хүүхэдтэйгээр илүү их цаг өнгөрөөх болсондоо баяртай байжээ. Хулна болон Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан цөөн тооны эмэгтэйчүүд мөн нөхөр, хүүхэдтэйгээ гэртээ хамт байж, илүү их цагийг хамтдаа өнгөрөөж, гэрийн болон хүүхэд харах ажилд тусалж байсан талаар ярьцгаасан.



Манай гэр бүл илүү ойр дотно болж, хамтдаа илүү их цаг өнгөрөөх болсон. Өмнө нь бид ажил ихтэй, бие биетэйгээ уулзах ч завгүй байдаг тул энэ нь эерэг мэдрэмж төрүүлсэн.

(Их сургуулийн багш эмэгтэй, Улаанбаатар)



Харин Хайдерабад хотод нөхцөл байдал огт өөр гэнэт ажил, орлогогүй болсон бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэйчүүд өөр орлогын эх үүсвэр олох, гэрийн ажил нэмэлтээр хийх зэрэг хүндрэлтэй тулгарчээ. Үүнээс үүдэн эмэгтэйчүүд гэр бүлийнхэнтэйгээ, ялангуяа нөхөртэйгөө зөрчилдөх болжээ. Нөхрүүдээс нь дэмжлэг хангалтгүй байсан, харин нутгийн иргэд, буяны байгууллагууд, нутгийн эмэгтэй ажилчдаас хамгийн хэрэгцээтэй байсан хүнсний тусламж авч байснаа илэрхийлсэн.

Улаанбаатар хотын хувьд бага насны хүүхэд асрах үүргийг гэр бүлийн гишүүн, садан төрлүүд гүйцэтгэж буй нь тэднийг гэрээс гадуур ажил эрхлэх боломжийг нээн өгдөг байна. Паксе, Луанг Прабанг болон Ванг Виен хотуудын хувьд аялал жуулчлалын салбарт ажиллаж байсан хүмүүс шинэ ажил олж хийхийн тулд гэр бүл, найз нөхдийнхөө тусламжид түлхүү найджээ. Тэдний шинэ ажил нь гэр бүл, найз нөхдийнх нь эрхэлж буй бизнесийн байгууллагуудад байсан ба энэ нь тэдэнд нөхцөл байдлыг даван гарах арга хэмжээ болжээ.



Өөр ямар ч дэмжлэг туслалцаа байгаагүй ... [эмээ, өвөө нараас өөр] ийм байдлаар л би давж гарсан."

(Гоо сайхны салоны ажилтан асан эмэгтэй, Улаанбаатар)



Жижиг бизнес эрхлэгч залуу эмэгтэй, Хулна, Бангладеш. Зургийг Collected. The Business Standard.

5. ЧАДАМЖ: ИРЭЭДҮЙД ҮЗҮҮЛЭХ БОЛОМЖИТ НӨЛӨӨЛӨЛ

Цар тахлаас үүдэлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн капиталтай холбоотой сөрөг нөлөөлөлд хамгийн их өртсөн хүмүүс цар тахлын дараа, дунд болон урт хугацаанд эргэн сэргэх эсэх асуудал өмнө нь тулгарч байна. Ирээдүйн сайн сайхан байдал, бие даасан байдал, боломж зэрэгт аюул учруулж болох салбаруудыг тодорхойлохын зэрэгцээ тэдгээр хүмүүсийн одоогийн сорилтыг даван туулах стратеги хэр зэрэг тогтвортой буйг үнэлэх нь эрсдэлд хамгийн их өртсөн иргэдийн байдал эргэн сэргэх эсэхийг хэмжих нэг арга хэлбэр мөн.

САНХҮҮГИЙН БАТАЛГААТ БАЙДЛАА ХАНГАХАД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Цар тахлаас үргэлжлэн үүдэж буй сөрөг нөлөө, төрийн зүгээс үзүүлж буй дэмжин туслах арга хэмжээний хүртээмжгүй байдлаас хамааран судалгаанд хамрагдсан олон талууд богино хугацааны дасан зохицох стратеги хэрэгжүүлэхээс өөр сонголтгүй болж, улмаар энэ нь тэдний санхүүгийн капиталд урт хугацаанд илүү ноцтой нөлөө үзүүлэх болжээ.

Хулна хотын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн гэр бүлийн, хувийн эд зүйлсийг зарж борлуулах, тэр ч байтугай бизнест шаардлагатай материалын нөөцөө бодит үнээс нь доогуур үнээр борлуулжээ. Судалгаанд хамрагдсан нэг эмэгтэйн зүгээс гар утсаа зарахаас өөр сонголтгүй болсон талаар дурдсан. Хайдерабад хотын бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийн хэлснээр тэд өөрийн үнэт эдлэл, шил шаазан эдлэл болон бусад эд зүйлсээ зарж борлуулжээ.



Би чихрийн шижин өвчтэй... Цар тахлаас болоод эм авч чадахаа больж, эрүүл мэнд муудахад хүрсэн ч эмэнд зарцуулах хангалттай мөнгө байгаагүй. Бусад хэрэгцээтэй зүйлсээ л

дөнгөж данган болгож байсан. Хүн бүхэн л ямар нэгэн зүйлээ зольсон.

(Гэрийн үйлчлэгч эмэгтэй, Хайдерабад)



Эмэгтэйчүүд мөн боломжийнхоо хэрээр бусдаас мөнгө зээлжээ. Ханой хотын үндэстний цөөнх цагаач ажилчид өөрийн түрээсийн төлбөр, хоол хүнс зэрэг суурь хэрэгцээг хангахын тулд төрөл садан, найз нөхөд, хамтран ажиллагчдаасаа мөнгө зээлж хэрэглэжээ. Вьетнам улсаас ярилцлагад хамрагдсан зарим хүмүүсийн зээлсэн мөнгөний хэмжээ их тул цар тахлын өмнөхөөс илүү ихээр санхүүгийн нөхцөл байдал нь мууджээ. Улаанбаатар хотын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд мөн ажилтнуудынхаа цалинг төлөх, байр орон сууц, ажлын өрөөний түрээсийн төлбөрөө төлөх, амьдралын суурь хэрэгцээгээ хангахын тулд зээл авцгаажээ. Хайдерабад хотын ярилцлагад хамрагдсан хүмүүс мөн хамаатан садан, хөршүүдээсээ зээл авсан байна. Авч буй цалин нь үндсэн хэрэгцээг нь хангаж хүрдэггүй, тухайн эмэгтэйчүүд нь гэрийнхээ цорын ганц орлого олдог хүн нь тул зээлээ эргэн төлж, эд хөрөнгөө нөхөхийн тулд маш урт хугацаа шаардагдана.

Ярилцлагад хамрагдсан заримынх нь хувьд цалин багатай ажил олсон эсвэл давхар ажил эрхлэх болжээ. Ханой хотын ажилчдыг бага цалинтай ажилд хүчээр шилжүүлжээ. Ажилгүй болсон бусад хэсэг нь зөвхөн цалин багатай ажилд орсон ба нэгэн эмэгтэйн зүгээс хэлэхдээ тэрээр цар тахлаас өмнө авч байсан цалингийнхаа талтай тэнцэх хэмжээний л цалин авах болсон байна. Ярилцлагад хамрагдсан олон эмэгтэйчүүд 2020 оны 3- 6 дугаар сард ажилгүй болж, тулгарсан нөхцөл байдлыг даван гарахын тулд одоо тал цалинтай ажиллаж байна. Энэ нь эмэгтэйчүүдэд дунд болон урт хугацаандаа санхүүгийн амжилт гаргахуйц сонголтот ажил эрхлэх боломж улам л хязгаарлагдана гэсэн үг юм. Тэдний олонх нь цаашид гэр бүлд нь тулгарсан урт хугацааны сэтгэл зүйн хямралыг даван туулах цаг хангалтгүй байх юм.



Гэр бүлээ тэжээхийн тулд орлого олох шаардлагатай байсан тул ажилгүй болоод үнэхээрийн дарамтад орсон. Би өөрийг л буруутгаж, өөр дээрээ дарамт шахалт үүрүүлсэн.

(Зочин хүлээн авагч асан эрэгтэй, Ванг Виенг)



Нөгөө талаар зарим бизнес эрхлэгч дасан зохицох стратеги хэрэгжүүлсэн нь цаашид тулгарах шокийг даван туулах илүү өндөр чадвар олгож болох юм. Жишээ нь Улаанбаатар болон Хулна хотуудад жижиг бизнес эрхлэгч зарим эмэгтэйчүүд цахим ур чадвар, мэдлэгээ ашиглан өөрийн бизнесийг онлайн хэлбэрт шилжүүлжээ. Эдгээр хотуудад ажиглагдсанаар энэхүү стратеги нь үндсэн болон гэрийн ажлын тэнцвэрийг хангах, ялангуяа хүүхдэд гэрээр хичээл заах боломжийг гарган өгчээ. Хулна хотын зарим оролцогч цалин орлого нь гэнэт тасалдсан нь гэр бүлээ тэжээх орлого олох шинэ арга замыг хайсан байна. Эмэгтэйчүүд нь бизнестээ шинэ бүтээгдэхүүн гаргах, сарий зардаг байсан бол цүнх, маск зэрэг шинэ зүйлс борлуулах зэргээр дасан зохицох гайхалтай чадварыг харуулжээ. Зарим эмэгтэйчүүд хувцас зарж байснаа зогсоон гэрээр дарсан өргөст хэмх зэрэг хүнсний бүтээгдэхүүн зарах бизнест шилжжээ.

Судалгааны хүрээнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс тэдний бизнест цар тахлаас үзүүлж буй урт хугацааны нөлөөллийн талаар асуун тодруулахад хамгийн өөдрөг нэг нь ч гэсэн эргэн сэргэхэд нэлээд хэдэн жил шаардлагатай хэмээн үзжээ. Зарим нь энэхүү нөлөөлөл байнга үргэлжлэн мэдрэгдэнэ хэмээн санаа зовниж байв. Ханой хотын цагаач ажилчин үндэстний цөөнхийн хувьд эргэн тосгондоо очсон ба цаашид тэндээ байнга байх эсэх нь тодорхойгүй байна. Нөгөө талаар бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зүгээс тухайн ажилчид нутаг буцсантай холбоотойгоор ажиллах хүчин хомсдож байна хэмээн хэлж байв.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ, АЛБАН ТУШААЛЫН ХЭТИЙН ТӨЛӨВТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Урт хугацаанд үргэлжлэх санхүүгийн баталгаат бус байдалдаа санаа зовнихын зэрэгцээ зарим эмэгтэйчүүд цар тахлаас тэдний цаашдын ажил албан тушаалын өсөлт, хувь хүний хараат бус байдалд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовниж байна. Тэдний зарим нь өнөөдрийн ажлын байраа баталгаатай хадгалахын тулд мэргэжлийн хөгжил, албан тушаал ахих төлөвлөгөөгөө орхих эсвэл хойшлуулжээ. Улаанбаатар хотод гэхэд төрийн албанд ажилладаг эмэгтэйчүүд санхүүгийн хүндрэл, ажлын ачаалал эсвэл ажил олгогч нь санхүүгийн дэмжлэгээ өгөхөө зогсоосноос үүдэн цаашид суралцах төлөвлөгөөгөө хойшлуулжээ. Лаос эмэгтэйчүүд өөр ажил эрхлэхийн тулд шинээр мэргэжил, ур чадвар эзэмшиж чадах эсэхдээ санаа зовж байна.

Олон тооны эмэгтэйн зүгээс хүүхэд, нөхөр болон гэр бүлийн бусад гишүүд нь гэртээ байх болсноос үүдэн цаг их шаарддаг гэрийн ажил үүрэг огцом нэмэгдсэн талаар дурдсан. Хүүхэд асрах ажил үүрэг нь цар тахлаас ч өмнө нь тэгш бус хуваарилалттай, үндсэндээ эмэгтэйчүүдийн нуруун дээр бууж байсан бол хөл хорио тавьж, сургууль хаагдсан үед улам нэмэгджээ. Монгол, Пакистан улсуудад ярилцлагад хамрагдсан харьцангуй өндөр орлоготой эмэгтэйчүүд хүртэл орлого тасарсан нь өрхийн динамикт сөргөөр нөлөөлснийг дурдсан. Улаанбаатар хотод л гэхэд хувийн хэвшлээс ажилгүй болсон эмэгтэйчүүд санхүүгийн хувьд нөхрөөсөө хамааралтай болж, зарим нь ажил, орлогогүй болсон нь өрхийн хэмжээнд гарч буй шийдвэрт нөлөөлөх боломжгүйд хүргэсний дурдаж байв.



Бүхий л зүйл дээр санхүүгийн холбоотой шийдвэр гаргахад нөхрөөсөө л асуудаг. Миний хүү тусдаа амьдардаг болохоор би нөхрөөсөө л мөнгө гуйх хэрэг гардаг.

(Бугуйвч үйлдвэрлэгч эмэгтэй, Хайдерабад)



6. 2021 ОНООС ЦААШ ХАРАХ НЬ

2020 оны 10 дугаар сараас 2021 оны 4 дүгээр сарын хооронд бидний хийсэн судалгаа нь коронавирусийн илүү хор хөнөөл бүхий Делта хувилбар Төв, Өмнөд болон Зүүн-Өмнөд Азийн улс орнуудад тархахаас өмнө үүдсэн цар тахлын нөлөөллийн талаар нарийвчлан судалсан. Энэ хугацаанаас хойш цар тахлын нөлөө улам эрчимжиж, капиталын хомсдолыг улам гүнзгийрүүлж, зах зээлд сөргөөр нөлөөлсөн нь мадаггүй юм. Энэхүү судалгаа нь хот суурин газруудын хүн амын эмзэг бүлгүүдэд цар тахлаас үзүүлсэн тэгш бус нөлөөллийг тодорхойлсон. Ажилчин эмэгтэйчүүд, үндэстний цөөнх болон бусад эмзэг бүлгийн иргэдийн ажлын байрны баталгаат байдал алдагдах, орлого буурах, төрөөс олгож буй дэмжлэг туслалцааны гадна үлдэх, нэмэлт ажил үүрэг гүйцэтгэх шаардлагатай болох зэрэг асуудалтай тулгарсан нь эмзэг бүлгийнхэн, эмэгтэйчүүдийн бие даасан, хараат бус байдлыг хязгаарлаж буй олон хүчин зүйлстэй хослон сөргөөр нөлөөлжээ. Эргэн сэргэх нь шугаман бус, ойрын хугацаанд үл тохиох тул өнөөгийн энэхүү тэгш бус байдлыг хэвээр хадгалах, бүр ч нэмэгдүүлэх томоохон эрсдэл үүсэж болно. Эргэн сэргэх боломжийг тэгш хангахын тулд хэд хэдэн нэгэн зэрэг хэрэгжиж бодлогыг шаардана.

ДНБ-ЭЭС ЦААШХЫГ ХАРАХ

Цар тахлын дараа эргэн сэргээх бодит, үр дүнтэй бодлого нь зөвхөн эдийн засаг, санхүүгийн өсөлтийн явцуу чиглэлд хязгаарлагдаж болохгүй. Эмэгтэйчүүд, ялангуяа хүүхдээ гэртээ үлдээж буй эмэгтэйчүүд, хамаатан садан эмэгтэйчүүд төр болон хувийн хэвшлээс үзүүлэх дэмжлэгийн хүртээмж хязгаарлагдмал байсны зэрэгцээ гэрийн ажил үүргийг тэгш бусаар гүйцэтгэх болжээ. Цар тахал нь цалинтай болон цалингүй гэрийн ажил, бусдыг асрах ажил нь өмнө нь хүлээн зөвшөөрдөггүй байсан ямар их үнэ цэнийг эдийн засаг, нийгэмд бий болгож байсныг тодруулан харуулсан байна. Дотоодын

нийт бүтээгдэхүүн гэх мэт эдийн засгийн уламжлалт хэмжүүр нь²⁹ эмэгтэйчүүдийн нуруун дээр байдаг албан бус, цалингүй гэрийн ажлыг тооцдоггүй тул ихээхэн алдаатай дүн гаргаж байдаг.³⁰ Үүний оронд бодлого боловсруулагчид, Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм нь цар тахлаас үзүүлсэн нөлөөллийг үнэлэх, ирээдүйн хямралд бэлтгэх, төрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үр ашигтай байдлыг үнэлэхдээ олон талт хэмжүүр бүхий, хүний болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлд мөн суурилсан аргачлалыг шинэчлэн сайжруулах, олж тогтоох, хэрэглэх шаардлагатай болжээ.³¹

ОДООГИЙН ҮЗҮҮЛЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ХАНГАХ

Төрөл бүрийн нийгмийн үйлчилгээг санал болгож буй ч эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэн хүртэж чадахгүй эсвэл үйлчилгээ авах боломжгүй буй хэд хэдэн салбар чиглэлийг бидний судалгаа хамарсан. Тулгарч буй сорилтуудын хувьд албан бус ажил эрхлэгчид, оршин суух бүртгэлгүй хүмүүсийг хамруулахад тусламжийн хөтөлбөр нь уян хатан бус, дүрэм журам нь ээдрээтэй, хөтөлбөрийн талаарх мэдлэг дутмаг байна. Хулна болон Улаанбаатар хотуудын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зүгээс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд нь санхүүгийн хүртээмжийн хувьд тэгш бус байгааг цохон дурдаж, цаашид илүү зорилтот дэмжлэг шаардлагатай, эмэгтэйчүүдэд санхүүжилтийн хүртээмжийг хангахын тулд зээлийн шалгуурыг өөрчлөх зэрэг нь чухал болохыг тэмдэглэн хэлсэн. Түүнчлэн олон улс орон төрийн үйлчилгээг цахимжуулж буйтай холбоотойгоор бидний судалгаа нь мөн олон хүмүүсийн интернэтийн хүртээмжгүй, ухаалаг утасгүй, интернэтийн хурдгүй, датагүй үлдээх цахим хуваагдлыг бууруулах, ингэснээр тухайн эмзэг бүлэгт үзүүлэх үйлчилгээ, үр өгөөжийг сайжруулахын ач холбогдлыг дэлгэрэнгүй тусгасан.

Засгийн газрууд нь мөн нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй зардлаа нэмэгдүүлэх, жишээ нь 15%-ийг эрүүл мэнд, 20%-ийг боловсролд зарцуулж буй дэлхий нийтийн зорилтыг хангах боломж, хандивлагч байгууллагууд нь энэхүү хөрөнгө оруулалтыг дэмжих боломж хэмээн ашиглах шаардлагатай.³²

ХАМГИЙН ИХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХЭСЭГТ СИСТЕМИЙГ ДАХИН ТӨВЛӨРҮҮЛЭХ

Судалгаанд оролцогчид үйлчилгээ авах боломжтой байсан ч тусламжийн олон хөтөлбөрийн үзүүлж буй дэмжлэг хангалтгүй байжээ. Тулгарсан хямралын сунжирсан онцлогийг харгалзан үзвэл Засгийн газрууд нь цар тахлаас хүмүүсийн амьжиргаа, сайн сайхан байдал, боломжуудад үзүүлж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээг өргөжүүлэх шаардлагатай байна. Цар тахлаас үзүүлж буй олон талд, тэгш бус нөлөөллийг анхааралдаа авч Засгийн газрууд нь хөгжлийн агентлагуудын тусламжтайгаар хүн амынхаа алдсан капиталыг нөхөн сэргээж эхлэх нь зүйтэй юм. Нөхцөлд бус мөнгөн тусламж зэрэг нийгмийн дэмжлэг туслалцааны хөтөлбөр, суурь орлогыг хангах зэрэг бодлогын арга хэмжээг судлан үзэх шаардлагатай байна.³³ Нийгмийн хамгаалал, халамжийн сүлжээнд илүү түгээмэл хандлагыг баримтлах нь төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хамрах хүрээ, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлж, зарим тохиолдолд нарийн төлөвлөөгүй хандлагаас үүдэн гарах нүсэр зардлыг бууруулна.³⁴

Үүнийг олон хуваагдсан хувь хүмүүст хандсан тусламжийн тогтолцоог халж илүү нэгдмэл, иж бүрэн нийгмийн хамгааллын тогтолцоонд³⁵ шилжин хот суурин газрын эмзэг бүлгийн иргэдэд тулгарч буй олон тооны эмзэг байдалд хандуулах шаардлагатай. Ийм төрлийн тогтолцоог бий болгох нь инфляц, эмнэлгийн тусламж шаардлагатай болох, өндөр нас, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, ирээдүйд гарч болох КОВИД-19 болон бусад цар тахлаас ард иргэдийг төрөл бүрийн шок, сорилтуудаас хамгаалахад чухал ач холбогдолтой. Иж бүрэн тогтолцоо нь Засгийн газар болон бусад оролцогч талуудад гамшигийн үеэр илүү үр дүнтэй, хурдтай арга хэмжээ авахад тус дэм болно.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ АЛБАН БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ

Хот суурин газрын эдийн засаг, тэр дундаа Өмнөд Азийн эдийн засаг нь дэд бүтцийн бүтээн байгуулалтаас эхлээд үйлчилгээ зэрэг олон салбарын албан бус ажилчдын үүрэг ролиос ихээхэн хамааралтай байдаг.³⁶ Тэдгээр ажилчдын эдийн засгийн эмзэг нөхцөлөөс гадна албан бус ажилчид нь хот суурин газруудад улс төрийн капитал хамгийн доод түвшинд байна. Түүнчлэн бидний судалгаагаар ядуу, эмзэг бүлгийнхэн эмзэг байдлаасаа гадна Засгийн газраас үзүүлж буй тусламжийн хөтөлбөрийн гадуур үлдэх нь их байна. Хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөв зохистой хэрэгжүүлэх, албан бус салбарын ажилчдын эрх зүйн хамгаалалтыг сайжруулах зэрэгт илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

АСАРГАА, ХҮҮХЭД ХАРАХ АЖЛЫГ ДАХИН ХУВААРИЛАХ

Асаргааны эдийн засагт буй гүн гүнзгий суурилсан жендэрийн нөлөөллийг нэн даруй засан залруулах шаардлагатай байна. Хүүхэд харах цалингүй ажил хийж буй эмэгтэйчүүдийн хараат бус байдал, боломж, шийдвэр гаргах эрх мэдлийг бууруулж буйг бидний судалгаа харуулсан. Охид, эмэгтэйчүүдийн нуруун дээр ирж буй цалингүй ажлыг бууруулах олон сонголт буйн тоонд нийгмийн хамгааллын тогтолцоог өргөтгөх, хүүхэд асрах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өндөр чанартай суурь үйлчилгээний хүртээмжийг тэргүүлэх чиглэлд оруулах, цалингийн системд буй жендэрийн ялгаатай байдлыг шийдэх, цалинтай болон цалингүй асаргааны ажлыг хослуулах боломжийг хангасан бодлого хэрэгжүүлэх зэрэг багтана.³⁷

Асаргааны эдийн засаг дахь ажил үүргийн хуваарилалтыг дахин хийхийн тулд гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарилалтыг захирч буй эр хүйс давамгайлсан хэм хэмжээг өөрчлөхөд төвлөрөх, мөн эрэгтэйчүүдийн зан төлөвийг өөрчлөхийн тулд идэвхтэй ажиллахыг шаардана. Төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн асаргаа, гэрийн ажлыг бууруулах, урамшуулах болон дахин хуваарилах боломжтой.

ИЛҮҮ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХОТУУДЫН ТӨЛӨӨ

Засгийн газар, орон нутгийн эрх баригчид нь хотууд нь нэгэн ижил бус, харин олон ялгаа бүхий хувь хүмүүс, бүлэг, хүй элгэний төлөөлөл байж, тэдний олонх нь бага орлоготой амьдарч, хотуудын нийгэм-эдийн засгийн цусны эргэлтийн салшгүй хэсэг болдог гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна. “Шинэ хэвийн байдал” эхлэхэд цар тахлаас өмнө ч эмзэг бүлэгт хамарч байсан тэдгээр хүмүүс л цар тахлын нөлөөллийг хамгийн ихээр мэдэрсэн.

Энэхүү тайланд тусгайлан дурдсан тэгш бус байдлыг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд, үндэстний олонх болон цөөнх, ажил олгогч болон ажилтан хооронд оршоор буй эрх мэдлийн тэгш бус харилцааг өөрчлөх замаар даван туулах боломжтой. Хөдөлмөр эрхлэлт, бизнес зэрэг олон нийтийн салбар дахь

тэгш бус байдлыг эмэгтэйчүүдийн эрх мэдэл, чөлөөт байдал нь хязгаарлагдаж, гэрийн ажил, хүүхэд асрах үүрэг нь тэгш бусаар хуваарилагдсан байдаг гэр гэр бүл, олон нийтийн дунд буй тэгш бус байдлын нэгэн адил анхаарч байх ёстой.

Өсөн нэмэгдэж буй эд баялаг, нийгэм болон орон зайн тэгш бус байдлыг хөндөн, зогсоохгүй бол эдгээр нь нийгмийн хэлхээ холбоо, эдийн засгийн эргэн сэргэлтэд урт хугацаандаа сөргөөр нөлөөлнө. КОВИД-19 цар тахал болон болон хямралын нөлөөнд хамгийн ихээр өртөж, асуудлуудыг өөр дээрээ мэдэрсэн хүмүүсийг л ойлгож, тэдний хэрэгцээнд нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр л цаашид тулгарах сорилтуудыг үр дүнтэй даван туулах бодлогыг боловсруулан гаргах боломжтой.



Монгол улс,
Улаанбаатар
хот, 2020 оны 12
дугаар сар. Зургийг
Ууганбаяр.

ТЭМДЭГЛЭЛ

- 1 Guterres,, A. (no date). [COVID-19 in an Urban World](#). New York: United Nations.
- 2 [COVID-19 in a Urban World](#), United Nations, Policy Brief, July 2020.
- 3 Weiss, Meredith L., et. al., "One War, Many Battles: COVID-19 in Urban Southeast Asia." Contemporary Southeast Asia: A Journal of International and Strategic Affairs, vol. 43 no.1, 2021, p. 1-7. Project Muse: <https://muse.jhu.edu/article/796888>
- 4 The [World Bank list of Lower Middle Income Economies in 2021](#) in Asia includes Bangladesh, Bhutan, Cambodia, India, Indonesia, Lao PDR, Mongolia, Myanmar, Nepal, Pakistan, Philippines, Sri Lanka, Timor-Leste and Vietnam.
- 5 Sharifi and Khavarian-Garmsir, The COVID-19 pandemic: impacts on cities and major lessons for urban planning, design, and manage- ment, Science of The Total Environment, Vol 747, December 20, 2020, 142391. <https://doi.org/10.1016/j.scitotenv.2020.142391>
- 6 Augsberg, B., Armand, A., & Bancalari, A. [Coping with COVID-19 measures in informal settlements](#). London: International Growth Center.
- 7 Benson Ang, [Covid-19 billionaires: Meet 20 men who thrived on the pandemic](#), The Strait Times, September 4, 2021, Accessed on October 14, 2021.
- 8 See, for example, Aiyar, S & Ebeke, C. (2018). Inequality of opportunity, inequality of income and economic growth, IMF Working Paper WP/19/34. Washington DC: International Monetary Fund.
- 9 Building Forward Fairer: Women’s rights to work and at work at the core of the COVID-19 Recovery, International Labour Organization, Policy Brief, July 2021.
- 10 The Glass Bangle Industry in Hyderabad, Pakistan, Vceela, accessed on September 02, 2021.
- 11 Энэхүү хүрээлэл нь эрдэмтэн, судлаачдын дараах бүтээл дээр сууилсан, Amartya Sen’s [Capability Approach, the Multi- dimensional Inequality Framework, and Kabeer, N. \(2016\) Leaving no one behind: the challenge of intersecting inequalities, World In. Challenging Inequalities: Pathways to a Just World](#). Paris: UNESCO.
- 12 Latdavanh, S. (2020). [The impact of COVID-19 on the Lao economy and its recovery post COVID-19](#). 2020 RIN Workshop Series on COVID-19. Jakarta: ERIA Research Institutes Network.
- 13 Лаос улсын Ерөнхий сайдын захирамж No. 16/CT-TT, 2020 оны 3 дугаар сарын 31.
- 14 TIN ĐỌC NHIỄU. (2020, 16 APRIL). [Thủ tướng nhất trí tiếp tục thực hiện Chỉ thị 16 ít nhất đến 22.4 tại một số địa phương. Báo điện tử Chính phủ Nước cộng hòa xã hội chủ nghĩa Việt Nam](#) [Ерөнхий сайдын зүгээс зарим мужуудад 16 дугаар захирамжийн үйлчлэх хугацааг сунгалаа (Unofficial translation)], Online Newspaper of the Government. Hanoi: The Socialist Republic of Vietnam.
- 15 Пакистан улсын Засгийн газар. (2020, 30 March). [Adviser to PM on Finance and Revenue chaired a special meeting ECC](#). Islamabad:
- 16 United Nations Development Programme (2020). [Development of high quality human resources for agriculture, new rural development and sustainable poverty reduction in Ethnic Minority and Mountainous Areas](#). New York: UNDP.
- 17 WHO, UNICEF, UNIDO, ILO, IFAD, FAO, and UN Women (2020). Phân Tích Của Liên Hợp Quốc Về Tác Động Xã Hội Của Đại Dịch Covid-19 Đối với Việt Nam Và Các Khuyến Nghị Chính Sách Chiến Lược. [[UN’s analysis on Covid-19 pandemic’s impacts in Vietnam and strategic policy recommendations](#)]. Hanoi: United Nations; Network of Action for Migrant Workers (M-Net). (2020). Bài trình bày về báo cáo tóm tắt kết quả nghiên cứu tác động về kinh tế - xã hội của đại dịch Covid-19 với nhóm yếu thế - người lao động di cư phi chính thức- tại Hà Nội và TP. Hồ Chí Minh [A presentation on summarized research report on the socioeconomic impacts of Covid-19 pandemic on the informal migrant workers in Hanoi and Ho Chi Minh city]. Unpublished.; Mekong Development Research Institute & UNDP (2020). [Citizen’s Opinions of and Experiences with Government Responses to Covid-19 Pandemic in Vietnam](#). Hanoi: PAPI; Tien Phong (2020). "Nghe từ lòng dân: khảo sát nhanh về gói hỗ trợ người dân gặp khó khăn do đại dịch Covid-19." [A rapid assessment on the implementation of social protection packages by the government for vulnerable groups]. Unpublished workshop report.
- 18 Anh, M. (2020, 10 April). [Vietnam approves \\$2.6 billion support package for COVID-19 crisis victims](#). VNExpress International.
- 19 Пакистан улсын Засгийн газар. (2020). [Adviser to PM on Finance and Revenue chaired a special meeting ECC](#). Islamabad: Finance Division.
- 20 *Ehsaas* гэдэг нь Урду хэлээр анхаарал халамж гэсэн утгатай.
- 21 Энэхүү схемийг өмнө нь Беназирын орлого дэмжих хөтөлбөр хэмээн нэрлэж байсан (Benazir Income Support Program).
- 22 Internal Crisis Group. (2020). [Pakistan’s COVID-19 Crisis](#). Crisis Group Asia Briefing N°162. Brussels: Internal Crises Group.

- 23 Mayabee, A. (2021, 27 June). [Is the SME sector adequately women-friendly?](#) The Daily Star.
- 24 Latdavanh, S. (2020). [The impact of COVID19 on the Lao economy and its recovery post COVID-19](#). 2020 RIN Workshop Series on COVID-19. Jakarta: ERIA Research Institutes Network; World Bank. (2021). [Lao Economic Monitor, January 2021: Supporting Economic Recovery](#). Washington DC: The World Bank Group.
- 25 Лаос улсын Засгийн газраас шууд туслалцааны ямар нэгэн хөтөлбөр хэрэгжүүлээгүй.
- 26 Зарим улсад чанга яригч нь төр болон иргэдийг холбох гүүр болдог. 1960-аад оноос хойш иргэний дайны үеэр бөмбөгдөлтийн талаар мэдээлэл хүргэж эхэлснээс хойш энэхүү системийг өнөө хүртэл хэрэглэж байна. Энэ нь мөн иргэдэд мэдээлэл түргэн хүргэдэг, ухаалаг утасны адил саатал гарах магадлал багатай систем юм. Гэвч иргэдийн зүгээс гудамж талбайд дуу чимээ их гаргаж байна хэмээн гомдол гаргах болсон тул Ханой хотын захиргаа үүнийг зогсооход ярилцаж байгаа. Энэхүү систем нь КОВИД-19 цар тахалтай холбоотой мэдээллийг иргэдэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.
- 27 Пакистан улсын Засгийн газар. (2018). [Labour Force Survey 2017-18 \(Annual Report\) 34th issue](#). Islamabad: Pakistan Bureau of Statistics.
- 28 Collective for Social Science Research. (2004). [A rapid assessment of bonded labour in hazardous industries in Pakistan: glass bangle-making, tanneries and construction](#). Geneva: International Labour Organization.
- 29 High-Level Expert Group on the Measurement of Economic Performance and Social Progress. (2018). [Beyond GDP: Measuring What Counts for Economic and Social Performance and For Good Measure Advancing Research on Well-being Metrics Beyond GDP](#). Paris: Organisation for Economic Cooperation and Development.
- 30 United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (UNESCAP) (2021). [Economic and Social Survey of Asia and the Pacific 2021](#). Bangkok: UNESCAP.
- 31 Жишээ болгон дараахыг үзнэ үү, McKnight, A., Mendes Loureiro, P., Vizard, P., Prats, P., Claver, A., & Kumar, C. (no date). [Multidimensional Inequality Framework](#). London: LSE Inequalities Institutes, LSE; andr Hoekstra, R. (2020). [Measuring the Wellbeing Economy: How to go beyond GDP](#). Wellbeing Economy Alliance.
- 32 Oxfam (no date). [Even it up Asia](#). London: Oxfam.
- 33 Hassan, H. et.al. (2021). [State of Governance in Bangladesh 2020-2021 - Governing COVID-19 in Bangladesh: Realities and Reflections to Build Forward Better](#). Dhaka: BRAC Institute of Governance and Development and Accountability Research Center.
- 34 International Labour Organization (ILO). (2020, 14 May). [Plug social protection gaps in developing countries to prevent future crises, ILO says](#). Geneva: ILO.
- 35 Junaid, A. (2019). [Schemes to Systems: The Future of Social Protection in India](#). New Delhi: The World Bank.
- 36 Chen, M. (2016, 16 August). [The Urban Informal Economy: Towards more Inclusive Cities](#). Urbanet.
- 37 Diallo, B., Quayum, S., & Staab, S. (2021). [COVID-19 and the care economy: Immediate action and structural transformation for a gender-responsive recovery](#). New York: UN Women.



The Asia Foundation

Азийн Сан нь эрч хүчтэй, хөгжин цэцэглэж буй Ази тивд амьжиргааг сайжруулах зорилго бүхий ашгийн бус, олон улсын хөгжлийн байгууллага юм. Нэгэн жарны туршид үйл ажиллагаа явуулсан туршлага, улс орнуудын талаарх өргөн хүрээний мэдлэг дээр суурилсан бидний үйл ажиллагаа нь сайн засаглал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендэрийн тэгш байдлыг хангах, эдийн засгийн тэгш хүртээмжийн өсөлтийг дэмжих, байгаль орчин болон уур амьсгалын асуудал, бүс нутгийн болон олон улсын харилцаа зэрэг чиглэлд төвлөрдөг.